# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (599)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Өршөөл үзүүлэх тухай*
- *Улсын бүртгэлийн ерөнхий хууль*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны долдугаар сарын 16 № 26 (599) Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 324. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 564 |
| 325. | Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | | 564 |
| 326. | Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 565 |
| 327. | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 565 |
| 328. | Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 566 |
| 329. | Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 566 |
| 330. | Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 567 |
| 331. | Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 567 |
| 332. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | | 568 |
| 333. | Улсын бүртгэлийн ерөнхий хууль | | 568 |
| 334. | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | | 573 |
| 335. | Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 574 |
| 336. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 574 |
| 337. | Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 575 |
| 338. | Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 575 |
| 339. | Санхүүжилтийн гэрээ соёрхон батлах тухай | | 575 |
| 340. | Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 575 |
| 341. | Өршөөл үзүүлэх тухай | | 576 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 342. | Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай | Дугаар 42 | 577 |
| 343. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 43 | 580 |
| 344. | Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай | Дугаар 44 | 580 |
| 345. | Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай | Дугаар 45 | 581 |
| 346. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 46 | 584 |
| 347. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 47 | 585 |
| 348. | Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Дугаар 48 | 585 |
| 349. | Кувейт Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай | Дугаар 52 | 585 |

350. Комисс байгуулах тухай Дугаар 53 585

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

351. Дорноговь аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 126 586
352. Дорнод аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 127 587
353. Дундговь аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 128 588
354. Завхан аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 129 589
355. Орхон аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 130 590

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

356. Журам батлах тухай Дугаар 72 591

Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

357. Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Дугаар 16 608
358. "Өршөөл үзүүлэх тухай" хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай Дугаар 27 609

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр** — **Улаанбаатар хот**

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн "төсвийн хүрээний мэдэгдлийн" гэсний өмнө "Үндсэн чиглэл," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн "Үндсэн чиглэл, төсвийг" гэснийг "Төсвийг" гэж, мөн зүйлийн 25.8 дахь хэсгийн "энэ хуулийн 25.4-т заасан" гэснийг "мөнгөний бодлогын" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "Энэ хуулийн 25.1-д заасан баримт бичгээс эхний ээлжинд" гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр** — **Улаанбаатар хот**

### ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн 2 дугаар зүйлийн хүснэгтийн 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.1.13 дахь заалт нэмсүгэй:

"16.1.13.малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого.".

**2 дугаар зүйл**. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2-24.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 27.3, 27.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл**. Энэ хуулийг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

"17.4. Анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид 2 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.

17.5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон энэ хуулийн 17.4-т заасан зөвшөөрлөөр 2 жил ажилласан их эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.".

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн дараахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"17.2. Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

17.3. Эмнэлгийн мэргэжилтэнд олгох мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь 2 ба 5 жилийн хугацаатай байна.".

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "Эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг дараахь тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр 6 сараас 1 жил 6 сар хүртэл хугацаагаар хүчингүй болгоно:" гэснийг "Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 23.3-т заасан Ёс зүйн хорооны шийдвэрийг үндэслэн дараахь тохиолдолд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сараас 1 жил 6 сар хүртэл хугацаагаар хүчингүй болгоно:" гэж, 17 дугаар зүйлийн 17.4, 17.5 дахь хэсгийн дугаарыг "17.7, 17.8" болгон тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн ", дадлагажигчаар ажиллуулах" гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зар сурталчилгааны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

**1/11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг:**

"11.6. Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нэвтрүүлж болно."

**2/14¹ дүгээр зүйл:**

**"14¹ дүгээр зүйл. Хатуулаг багатай дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа**

14¹.1. Нийтийн хэвлэл захиалгад орсон сонин, сэтгүүл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг дор дурдсан нөхцөлөөр нийтэлж болно:

14¹.1.1. өдөр тутмын сонин нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр долоо хоногт 1 удаа;

14¹.1.2. энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад сонин нэг удаагийн дугаарын хэвлэлийн нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа;

14¹.1.3. сэтгүүл нэг удаагийн дугаарын нэг нүүрнээс хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа.

14¹.2. 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу интернэтээр түгээж болно.

14¹.3. 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нь согтууруулах ундааны хэрэглээг уриалсан шинжтэй байж болохгүй бөгөөд уг зар сурталчилгаанд "Хэтрүүлэн хэрэглэх нь таны эрүүл мэндэд хортой" гэсэн санамж, анхааруулгыг заавал хэрэглэсэн байна.

14¹.4. 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архийг үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгж нь нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих зорилгоор ивээн тэтгэсэн, санхүүжүүлсэн, хандив өгсөн бол уг арга хэмжээг зохион байгуулж байгаа газарт тухайн бүтээгдэхүүнээ сурталчилсан ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад сурталчилгааны хэрэгслийг байрлуулж болно.".

**2 дугаар зүйл.** Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтын "10-14," гэсний дараа "14¹," гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 9.2.7 дахь заалт нэмсүгэй:

"9.2.7. Зар сурталчилгааны тухай хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа явуулах.".

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталсан Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 19-ний өдөр** **Улаанбаатар хот**

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Биеийн тамир, спортын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

**1/ 3 дугаар зүйлийн 3.1.10, 3.1.11 дэх заалт:**

"3.1.10."биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага" гэж биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажил, үйлчилгээ үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.11. "чийрэгжүүлэлт" гэж хүний хөдөлгөөний идэвхийг сайжруулах замаар эрүүл мэндийг бэхжүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг."

**2/ 8¹ дүгээр зүйл:**

**"8¹ дүгээр зүйл. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэл**

8¹.1. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэлийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага, шинжээч хэрэгжүүлнэ.

8¹.2.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэл хийх байгууллага, шинжээч нь биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллагын үйл ажиллагааны түвшин, чанарт хөндлөнгийн мэргэжлийн шинжилгээ-үнэлгээ хийж дүгнэлт гаргана.

8¹.3.Магадлан итгэмжлэх, шинжээч ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

**3/ 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалт:**

"9.3.5.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах;".

**2 дугаар зүйл**.Биеийн тамир, спортын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт:**

"7.1.4.олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах болон үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам батлах;"

**2/16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:**

"16.3.Үндэсний хэмжээний болон Монгол Улсад олон улсын хэмжээний тэмцээн, уралдаан, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.".

**3 дугаар зүйл**. Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтын "дэлхий, тивийн аварга" гэснийг "тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн" гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалтын дугаарыг "9.3.6" болгон тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл**.Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зҮйлийн гарчгийн "бодлого," гэснийг хассугай.

**5 дугаар зүйл**.Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дҮгээр зҮйлийн 4.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 18.15 дахь хэсэг нэмсүгэй:

"18.15. Хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана.".

**2 дугаар зүйл.** Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.5. дахь заалтын "бусад байгууллагын" гэсний өмнө "төрийн болон төрийн бус" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт:**

"6.1.5. хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх;"

**2/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:**

"18.4. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээс санал авах ажиллагааг дараах хэлбэрээр зохион байгуулна:

18.4.1. хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах;

18.4.2. хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно.".

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:**

"10/ өргөдөл, гомдол хүлээн авах үүрэг бүхий ажилтан өргөдөл, гомдлыг тогтоосон хугацаанд нь шийдвэрлэх албан тушаалтанд хүргэх."

**2/ 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

"3. Байгууллагын удирдлага нь тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи дүн мэдээг жил бүр нийтэд тайлагнана."

**3/ 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**"3.Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нь өөр байгууллага, албан тушаалтан шийдвэрлэхээр хуульд шууд заасныас бусад өөрийн эрхлэх асуудлын хүрээ, хуулиар хүлээсэн чиг үүрэгт нь хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг доод шатны байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхгүйгээр эцэслэн хариу өгнө."

**4/ 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

"3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаа хожимдуулан хариу өгсөн нь Төрийн албаны тухай хуулийн 26.1-д заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно."

**2 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Байгууллага бүр цахим хаягтай байна." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 6 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсэгт заасныг зөрчсөн бол сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж өргөдөл, гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулна."

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Улаанбаатар хот**

### УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Улсын бүртгэлийн хууль тогтоомж**

2.1. Улсын бүртгэлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Иргэний бүртгэлийн тухай[3], Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай[4], Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль[5], энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ

[1] Монгол Улсын үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугээрт нийтлэгдсэн.
[2] Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[3] Иргэний бүртгэлийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 49 дүгээрт нийтлэгдсэн.
[4] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн.
[5] Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Улсын бүртгэлийн зарчим**

3.1.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.1.1.нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх;

3.1.2.төвлөрсөн удирдлагатай байх;

3.1.3.хараат бус байх;

3.1.4.үнэн зөв, бодитой, заавал биелүүлэх шинжтэй байх;

3.1.5.нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх;

3.1.6.иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, нууцыг чанд хадгалах.

**4 дүгээр зүйл. Улсын бүртгэл, түүний нэгдсэн тогтолцоо**

4.1.Эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг улсын бүртгэл гэнэ.

4.2.Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо дараах хэсгээс бүрдэнэ:

4.2.1.иргэний улсын бүртгэл;

4.2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэл;

4.2.3.эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл.

4.3.Иргэний эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг иргэний улсын бүртгэл гэнэ.

4.4.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн бүртгэлийн үйл ажиллагааг хуулийн этгээдийн улсын бүртгэл гэнэ.

4.5.Өмчийн хэлбэр, өмчлөгчийн иргэний харьяалал харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл гэнэ.

**5 дугаар зүйл. Улсын бүртгэлийг хөтлөх**

5.1.Улсын бүртгэлийг энэ хуулийн 5.3-5.5-д заасан мэдээлэл бүхий нотлох баримтад үндэслэн хөтөлнө.

5.2.Улсын бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан улсын бүртгэл хөтлөх журмын дагуу хөтөлнө.

5.3.Иргэний улсын бүртгэл дараах төрөлтэй байна:

5.3.1.төрсний;

5.3.2.гэрлэсний;

5.3.3.гэрлэлт цуцлуулсны;

5.3.4.гэрлэлт сэргээсний;

5.3.5.эцэг тогтоосны;

5.3.6.үрчилсний;

5.3.7.овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний;

5.3.8.нас барсны;

5.3.9.иргэний үнэмлэхийн;

5.3.10.гадаадад зорчих эрхийн;

5.3.11.биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/;

5.3.12.иргэний байнгын оршин суугаа газрын;

5.3.13.шилжилт хөдөлгөөний;

5.3.14.Монгол Улсын харьяатаас гарсан, харьяат болсон, харьяалал сэргээсний.

5.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл дараах төрөлтэй байна:

5.4.1. хуулийн этгээдийн нэр, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн;

5.4.2. хуулийн этгээдийг байгуулсан тухай /шинээр, эсхүл өөрчлөн байгуулсан/;

5.4.3. хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн болон үүсгэн байгуулах баримт бичиг, түүнд орсон өөрчлөлтийн;

5.4.4. хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох тухай /өөрчлөн байгуулах, татан буулгах/;

5.4.5. өөрчлөн байгуулах замаар шинээр үүссэн болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын;

5.4.6. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаарын;

5.4.7. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтад орсон өөрчлөлтийн;

5.4.8. тухайн хуулийн этгээд салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын хууль ёсны хаягийн;

5.4.9. компани бол түүний хувьцааг эзэмшиж байгаа этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийн;

5.4.10. компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан өөрийн хөрөнгийн хэмжээний;

5.4.11. хуулийн этгээдийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн;

5.4.12. хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал, иргэний үнэмлэх, бичиг баримт болон татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

5.4.13. жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний.

5.5. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл дараах төрөлтэй байна:

5.5.1. эд хөрөнгө өмчлөх эрхийн;

5.5.2. эд хөрөнгө эзэмших эрхийн;

5.5.3. эд хөрөнгө ашиглах эрхийн;

5.5.4. барьцааны;

5.5.5. батлан даалтын;

5.5.6. түрээсийн;

5.5.7. сервитутын;

5.5.8. узуфруктын;

5.5.9. бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн;

5.5.10. санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээний эрхийн.

**6 дугаар зүйл. Улсын бүртгэлийн журам**

6.1.Энэ хуулийн 5.3-5.5-д заасан улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо, удирдлага, чиг үүрэг

**7 дугаар зүйл. Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо**

7.1. Монгол Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо нь улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар, нэгж, ажилтнаас бүрдэх бөгөөд хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

7.2. Улсын бүртгэлийн байгууллага нь нэгдмэл тогтолцоо, төвлөрсөн удирдлагатай байна.

7.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

7.4. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг байгууллага үүрэг, зорилтоо бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

7.5. Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгж, ажилтны бүртгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

**8 дугаар зүйл. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

8.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

8.1.2. бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

8.1.3. улсын бүртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;

8.1.4. улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;

8.1.5. Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;

8 1.6. салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавхи, техник технологи, програм хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

8.1.7. улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;

8.1.8.улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх;

8.1.9.улсын бүртгэгчийг бэлтгэх , мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;

8.1.10.улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасан журмын дагуу баталж мөрдүүлэх;

8.1.11.улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх;

8.1.12.улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

**9 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх**

9.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах;

9.1.2. улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

9.1.3. улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдүүлэх;

9.1.4. улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжийн дарга, улсын бүртгэгчийг томилж, чөлөөлөх;

9.1.5. улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, түүний хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

9.1.6. улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийг шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

9.1.7. улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

9.1.8.улсын бүртгэлийн байгууллага, албан хаагч, бусад ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

9.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**10 дугаар зүйл. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих**

10.1. Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан нэгж нь хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ.

10.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Ерөнхий байцаагч байна.

10.4. Ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, хяналтын улсын ахлах байцаагч болон хяналтын улсын байцаагчийн эрхийг Ерөнхий байцаагч олгоно.

10.5. Хяналтын улсын ахлах байцаагч болон хяналтын улсын байцаагч нь Засгийн газрын баталсан Улсын бүртгэлийн хяналтын дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

10.6. Улсын байцаагч нь улсын бүртгэгчийн эрхтэй байна.

**11 дүгээр зүйл. Улсын бүртгэгч, түүний эрх, үүрэг**

11.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Улсын ерөнхий бүртгэгч байх бөгөөд Улсын ерөнхий бүртгэгч нь улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, түүний хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

11.2.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад Улсын ерөнхий бүртгэгч, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, орон нутаг дахь салбар, нэгжид улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч ажиллана.

11.3.Дээд боловсролтой, улсын бүртгэгч бэлтгэх сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэнийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга улсын бүртгэгчээр томилж, чөлөөлнө.

11.4.Улсын бүртгэгч нь хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэнэ.

11.5.Улсын бүртгэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

11.5.1.улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг нотлох баримт, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

11.5.2.энэ хуулийн 5.3-5.5-д заасан улсын бүртгэл хийлгэх тухай хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримт бичгийг хүлээн авч хянан улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах;

11.5.3.энэ хуулийн 11.5.2-т заасан нотлох баримт нь зөрчилтэй, бүрэн бус, холбогдох хуулийн заалтыг зөрчсөн бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах;

11.5.4.тухайн улсын бүртгэлтэй холбоотой албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэмдэглэлийг эх нотлох баримт болгон авч улсын бүртгэлийн архивын хувийн хэрэгт хавсарган баяжилт, бүртгэл хийх;

11.5.5.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн талаар шүүх, цагдаа, прокурор зэрэг эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу улсын бүртгэлд өөрчлөлт, тэмдэглэл хийж, шийдвэрийг бүртгэлийн хувийн хэрэгт хавсарган хадгалж, баяжилт хийх;

11.5.6.улсын бүртгэлийн талаарх цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, түүний хамгаалалт, найдвартай байдлыг хангах;

11.5.7.улсын бүртгэлийн талаарх мэдээлэл, лавлагааг иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу гаргаж өгөх;

11.5.8.улсын бүртгэлийн хувийн хэргийг хөтлөх;

11.5.9.шүүх, цагдаа, прокурор зэрэг эрх бүхий бусад байгууллагад зохих журмын дагуу лавлагаа өгөх, улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар туслалцаа үзүүлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах;

11.5.10.улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээ гаргах, хуулийн дагуу мэдээлэх;

11.5.11.улсын бүртгэлийг хараат бусаар үнэн зөв хөтлөх;

11.5.12.өөрийн гүйцэтгэсэн улсын бүртгэлийн хувийн хэргийн нотлох баримтын бүрдэл болон түүний үнэн зөвийг хуулийн өмнө хариуцах;

11.5.13.улсын бүртгэлтэй холбоотой төр, хувь хүн, байгууллагын нууцыг хадгалах;

11.5.14.шаардлагатай гэж үзвэл үл хөдлөх эд хөрөнгө байгаа газар биечлэн очиж, түүний хэмжээ, байршилтай танилцах;

11.5.15.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан

**12 дугаар зүйл. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан**

12.1.Монгол Улс бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд уг сан нь төрийн өмч байна.

12.2.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн эх нотлох баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

12.3.Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код, регистрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,Үндэсний статистикийн хороо хамтран батална.

12.4. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэл улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн суурь мэдээлэл болох бөгөөд бичгэн хэлбэрийн мэдээлэл нь эх сурвалж болно.

12.5. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.

12.6. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон түүний харьяа салбар, нэгж хүлээнэ.

12.7.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж байгаа мэдээлэлд тухай бүр баяжилт хийнэ.

12.8.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь Үндэсний дата төвд хадгалагдах бөгөөд Үндэсний дата төвийн болон улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах журмыг Засгийн газар батална.

12.9.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ажлын шаардлагаар ашиглаж байгаа этгээд тухайн мэдээлэлтэй холбоотой нууцыг хадгалах үүрэгтэй.

12.10. Лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр олгож болно.

**13 дугаар зүйл. Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив**

13.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийг бүртгэж баталгаажуулахад ач холбогдолтой эх нотлох баримт бичгийн төрөлжсөн архивыг улсын хэмжээнд үүсгэн нөхөн бүрдүүлэлт, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангана.

13.2.Улсын бүртгэлийн эх нотлох баримтыг архивт хадгалах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

13.3.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын бүртгэлийн хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлт, баяжилтын болон хаасан улсын бүртгэлийн хувийн хэргийн мэдээг сар, улирал, жилээр улсын хэмжээнд нэгтгэн гаргана.

**14 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан**

14.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангана.

14.2.Цахим мэдээллийн сан дахь мэдээллийг хуулбарлан, технологийн дагуу хадгална.

14.3.Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл өгөх

**15 дугаар зүйл. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл өгөх**

15.1. Хуулиар хориглосноос бусад улсын бүртгэлийн мэдээлэл нээлттэй байна.

15.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа салбар, нэгж, ажилтан лавлагаа, мэдээлэл авах тухай хүсэлт, мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж хариу өгнө.

15.3.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа салбар, нэгж, ажилтан улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас өгсөн лавлагаа, мэдээлэлд байгууллагын тэмдэг дарж, архивын эх нотлох баримт бичгийн хуулбарт "хуулбар үнэн" гэсэн тэмдэг дарж тус тус баталгаажуулсан байна.

15.4.Улсын бүртгэлийн талаар лавлагаа, мэдээлэл, хуулбар авсан этгээд уг мэдээллийг ашиглан тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

15.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд дор дурдсан тохиолдолд улсын бүртгэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө:

15.5.1.тухайн мэдээлэлд холбогдох этгээд өөрөө бичгээр зөвшөөрсөн;

15.5.2.хууль хяналтын болон тусгайлан эрх олгогдсон төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтны албан ёсны хүсэлтийг үндэслэн тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралтай лавлагаа, мэдээллийг өгч болно.

15.6.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 15.5.2-т заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан журмын дагуу үнэ төлбөргүй лавлагаа, мэдээлэл өгнө.

15.7.Эрүү, иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалахад шаардлагатай лавлагаа, мэдээллийг бүртгэлийн байгууллагаас гаргуулах тухай хүсэлтээ уг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтнаар дамжуулан авна.

15.8.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын бүртгэлийн тоон мэдээг Үндэсний статистикийн хороо, Төв банк, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад улирал бүр гаргаж өгнө.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**16 дугаар зүйл. Улсын бүртгэлийн байгууллагаас төрийн байгууллагатай харилцах**

16.1.Бүх шатны төрийн байгууллага улсын бүртгэлийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.

16.2.Улсын бүртгэлийн байгууллагад хууль хяналтын байгууллага, татварын албанаас мэдээлэл ирүүлэх журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

16.3 Хууль хяналтын байгууллага улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар гаргасан шийдвэрээ улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа салбар, нэгжид ажлын 3 өдрийн дотор ирүүлнэ.

16.4. Улсын бүртгэлийн байгууллагын архивын хувийн хэрэг, эх баримтаас нотлох баримтад шинжилгээ хийх эрх бүхий этгээд зөвхөн архивт ирж үзлэг, шинжилгээ хийнэ.

**17 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг**

17.1.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

17.2. Иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

17.3.Улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа этгээд нь бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө.

**18 дугаар зүйл. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

18.1. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

18.1.1. улсын бүртгэгч нь үйлчлүүлэгчид хууль бус шаардлага тавих, зүй бусаар харьцах;

18.1.2. өөрийн чиг үүрэгт хамааралгүй мэдээллийг цуглуулах, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас авч үзэх;

18.1.3. хүлээж авсан хүсэлт, эх нотлох баримт болон эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн бичилтэд засвар хийх, гэмтээх, устгах, үрэгдүүлэх, нотлох баримтыг хууль бусаар нэмэх хасах;

18.1.4. улсын бүртгэлийн байгууллагын тооцоолох машины зөөгч болон санах байгууламжид хадгалсан тооллого, түүвэр судалгаа, мэдээллийн боловсруулалтын дэлгэрэнгүй материалыг тогтоосон хугацаанаас өмнө устгах, бусдад дамжуулах, худалдах;

18.1.5. улсын бүртгэлийн дугаарыг давхардуулж, эсхүл алгасаж олгох;

18.1.6. лавлагааны дугаарыг давхардуулж, эсхүл алгасаж олгох;

18.1.7. улсын бүртгэлийн хувийн хэрэг, гэрчилгээ, лавлагааны бичилтийг засварлах, улсын бүртгэл хийсэн он, сар, өдөр, цагийг буруу бичих;

18.1.8. улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох;

18.1.9. улсын бүртгэгч өөрийн хувийн дугаар бүхий тэмдгийг хууль бус үйлдэлд хэрэглэх, бусдад ашиглуулах, өөр бүртгэгчийн тэмдгийг ашиглах;

18.1.10. улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх;

18.1.11.улсын бүртгэгч үүрэгт ажлаа гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авах;

18.1.12.лавлагаа, мэдээллийг энэ хуулийн 15.2, 15.3, 15.5-д зааснаас бусад байдлаар өгөх, эсхүл нотлох баримтаас зөрүүтэй, хуурамчаар гаргаж өгөх;

18.1.13.улсын бүртгэлийн дүн мэдээг дур мэдэн өөрчлөх.

18.2.Улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архивын хувийн хэрэгтэй улсын бүртгэгч, улсын ахлах бүртгэгч, Улсын ерөнхий бүртгэгчээс бусад этгээд танилцах, түүнд өөрчлөлт, баяжилт хийхийг хориглоно.

18.3.Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичиг бүхий архивын хувийн хэргийг байгууллагын байрнаас гаргахыг хориглоно.

18.4.Улсын бүртгэлийн байгууллагаас бусад иргэн, хуулийн этгээд энэ хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

**19 дүгээр зүйл.Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлс**

19.1.Хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, лавлагаа, мэдээлэл өгөхөд үйлчилгээний хөлс төлнө.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно.

**20 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх**

20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан улсын бүртгэлтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

**21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

21.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бүртгэлийн хяналтын улсын байцаагч Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** — **Улаанбаатар хот**

### ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1-6.4 дэх хэсэг, 6.6, 6.7 дахь хэсэг, 8,10-12, 37, 38 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

### ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Иргэний хууль," гэсний дараа "Улсын бүртгэлийн ерөнхий хууль," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл**. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1, 18.9 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3, 19.5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5, 22.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1, 32.3, 32.4 дэх хэсгийн "Засаг даргын тамгын газар" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтан" гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3, 11.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн "хууль зүйн" гэснийг "улсын бүртгэлийн" гэж, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн "Засаг даргын тамгын газрын" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн" гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн "Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн" гэж, 12 дугаар зүйлийн 12.5, 12.12 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, 14.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2, 16.7 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.4, 19.6 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "Засаг даргын тамгын газарт" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтанд" гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн "Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтан" гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "Засаг даргын тамгын газар" гэснийг "улсын бүртгэлийн асуудал хариуцсан алба" гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн "сум, дүүргийн Засаг даргын, эсхүл иргэний бүртгэл, мэдээллийн" гэснийг "улсын бүртгэлийн" гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн "сум, дүүргийн Засаг даргын болон иргэний бүртгэл, мэдээллийн" гэснийг "улсын бүртгэлийн" гэж, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийн "Энэ хуулийн 38.2.-т заасан гэснийг "Бүртгэлийн" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл**. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 29.5-29.8, 29.11, 38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл**. Энэ хуулийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 44.4 дэх хэсэг нэмсүгэй:

"44.4.Төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын "хуулбар үнэн" гэсэн тэмдэг дарж баталгаажуулна."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан "Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Монгол Улсын Үндэсний статистикийн системийг сайжруулах төсөл"-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Хөгжлийн бодлогын санхүүжилт" хөтөлбөрийн Санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан "Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09- ний өдөр

Улаанбаатар хот

# ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Өршөөл үзүүлэх тухай хууль тогтоомж**

2.1.Өршөөл үзүүлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Эрүүгийн хууль[2], Эрүүгийн байцаан шийтгэх хууль[3], энэ хуулиас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хууль үйлчлэх цаг, хугацаа**

3.1.Энэ хууль 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс /6 дугаар сарын 23-ны 24.00 цагаас/ өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамаарна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ХЭЛБЭР, ХҮРЭЭ, ХЭМЖЭЭ

**4 дүгээр зүйл. Ялаас өршөөн хэлтрүүлэх**

4.1.Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн дор дурдсан ялтны шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ:

4.1.1.арван найман насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэгт ял эдэлж байгаа;

4.1.2.арван найман насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүд болон жирэмсэн эмэгтэйчүүд;

4.1.3.ял эдэлж байхдаа бие махбодидоо санаатайгаар гэмтэл учруулснаас бусад шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс;

4.1.4.жараас дээш насны эрэгтэйчүүд, тавин таваас дээш насны эмэгтэйчүүд;

4.1.5.арван найман насанд хүрээгүй хүүхэд;

4.1.6.өөрийн шууд асрамжид байгаа арван найм хүртэл насны хагас өнчин хүүхэдтэй эрэгтэйчүүд.

4.2.Энэ хуулийн 4.1.5-д заасан этгээдэд энэ хуулийн 8.1.7 дахь заалт хамаарахгүй.

4.3.Болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ.

4.4.Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн, түүнчлэн хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж, анх удаа хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ.

**5 дугаар зүйл. Ялаас өршөөн хасах**

5.1. Дор дурдсан ялтны эдлээгүй үлдсэн ялыг дараахь байдлаар өршөөн хасна:

5.1.1. хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн хорих ялаас гурван жилийг;

5.1.2. онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн хорих ялаас хоёр жилийг.

**6 дугаар зүйл. Зарим хугацааг хэрэгсэхгүй болгох**

6.1. Дор дурдсан хугацааг хэрэгсэхгүй болгоно:

6.1.1. энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ял эдэлж дууссан этгээдийн Эрүүгийн хуулийн 78.2 дахь хэсэгт заасан ялгүй болох хугацаанаас үлдсэн хугацааг;

6.1.2. хорих ялыг нь тэнссэн этгээдийн хянан харгалзах хугацаанаас үлдсэн хугацааг;

6.1.3. хорих газраас тэнсэн суллагдсан этгээдийн хянан харгалзах хугацаанаас үлдсэн хугацааг;

6.1.4. насанд хүрээгүй хүүхэд болон жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх ажиллагааг хойшлуулсан хугацаанаас үлдсэн хугацааг.

**7 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох**

7.1. Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгоно.

**8 дугаар зүйл. Өршөөлд хамааруулахгүй нөхцөл байдал**

8.1. Дор дурдсан этгээдийг энэ хуульд заасан өршөөлд хамааруулахгүй:

8.1.1.цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн ял нь уучлагдан хорих ялаар солигдсон;

8.1.2.онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон;

8.1.3.гурав ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн;

8.1.4.урьд санаатай гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж байсан этгээд Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүйд тооцох хугацаа болоогүй байхад гэмт хэрэг санаатай үйлдэж, дахин хорих ял шийтгүүлсэн;

8.1.5.өршөөл үзүүлэх тухай 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хууль, 2000 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хууль, 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өршөөгдсөнөөс хойшхи хугацаанд гэмт хэрэг санаатай үйлдсэн;

---

[1] Монгол Улсын үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугээрт нийтлэгдсэн.
[2] Монгол Улсын Эрүүгийн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.
[3] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

***8.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар уучлагдан хорих ялаас чөлөөлөгдсөний дараа гэмт хэрэг санаатай үйлдсэн;***

8.1.7.Төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 79-85 дугаар зүйл/, Хүнийг санаатай алах /Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйл/, Хүн хулгайлах /Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйлийн 108.2, 108.3 дахь хэсэг/, Хүн худалдаалах /Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2, 113.3 дахь хэсэг/, Хүчиндэх /Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэг/, Бусдын эд хөрөнгийг хулгайлах /Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэг/, Бусдын эд хөрөнгийг булаах /Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлийн 146.4 дэх хэсэг/, Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэг/, Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах /Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.3, 148.4 дэх хэсэг/, Зандалчлах /Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйл/, Терроризм /Эрүүгийн хуулийн $178^1$ дүгээр зүйл/, Терроризмыг санхүүжүүлэх /Эрүүгийн хуулийн $178^2$ дугаар зүйл/, Терроризмыг сурталчлах /Эрүүгийн хуулийн $178^3$ дугаар зүйл/, Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах, түүнд оролцох /Эрүүгийн хуулийн 182 дугаар зүйлийн 182.3 дахь хэсэг/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах /Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3 дахь хэсэг/, Эрүү шүүлт тулгах /Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсэг/, Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох /Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлийн 261.2 дахь хэсэг/, Хээл хахууль авах /Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйл/, Мөнгө угаах /Эрүүгийн хуулийн $268^1$ дүгээр зүйлийн $268^1.2$, $268^1.3$ дахь хэсэг/, Хээл хахууль өгөх /Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэг/, Хээл хахууль зуучлах /Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэг / -т тус тус заасан гэмт хэрэг үйлдсэн.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**
**ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

**9 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

9.1. Энэ хуулийг 2009 оны 7 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

9.2. Хорих анги болон баривчлах байранд ял эдэлж байгаа ялтанд энэ хуулиар өршөөл үзүүлэх ажлыг 2009 оны 7 дугаар сарын 30-ны дотор багтаан гүйцэтгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр** **Дугаар 42** **Улаанбаатар хот**

**Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2010 оны төсвийн хүрээний мэдэгдлийн болон 2011-2012 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийг 1 дүгээр хавсралтаар, Засгийн газрын дунд хугацааны зорилтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийн төслийг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтүүдийг баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3. Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэж батлахдаа энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтүүдийг баримталж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/, Төсвийн байнгын хороо /Ч.ХҮрэлбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

**Монгол Улсын Их Хурлын 2009 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН БОЛОН 2011-2012 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

| | Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд | | Төсөөлөл | |
|---|---|---|---|---|
| | | 2010 он | 2011 он | 2012 он |
| 1 | ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь | 7.0 | 8.2 | 9.0 |
| | **ДНБ-д эзлэх хувиар** | | | |
| 2 | Төсвийн нийт орлогын доод хэмжээ | 31.6 | 28.0 | 27.0 |
| 3 | Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ | 35.6 | 31.0 | 29.0 |
| 4 | Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ | 2.6 | 3.6 | 4.6 |
| 5 | Төсвийн алдагдлын дээд хэмжээ | -4.0 | -3.0 | -2.0 |
| 6 | Хөрөнгийн зардлын доод хэмжээ | 5.8 | 4.5 | 4.7 |

**Монгол Улсын Их Хурлын 2009 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2011-2012 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД

Засгийн газрын дунд хугацааны зорилт нь хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн удирдлагын ил тод, шуурхай, шударга, хариуцлагатай байдлыг хангах, хүн амын түмний амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэгдэнэ.

**Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.**

1.1. Стратегийн болон бусад ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувийн хэвшил, бодит салбарын үйлдвэрлэлийг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хангах.

1.2. Эдийн засгийн бүтцийг сайжруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх бодлого баримтлах.

1.3. Инфляцийг бууруулах, төсөв, мөнгө, санхүү, эдийн засгийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлэх.

1.4. Санхүү, эдийн засгийн хямралт байдлыг даван туулах цогц арга хэмжээ авч, түүний дараах эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, нийт эдийн засаг дахь Засгийн газрын оролцоог багасгах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн эрүүл хөрс, суурийг бэхжүүлэх.

1.5. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг багасгах бодлого баримталж, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

**Хоёр. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хадгална.**

2.1. Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг бататгах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, бодит салбарын хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлого явуулах.

2.2. ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг огцом алдагдуулалгүйгээр тогтвортой түвшинд байлгах чиглэл баримталж, төсвийн алдагдлыг 2009 оны түвшнээс өсгөхгүйгээр аажмаар бууруулах.

2.3. Төсвийн орлогын бололцоотой бүх эх үүсвэрийг бүрэн дайчилж, оновчтой хуваарилан үр өгөөжтэй ашиглах.

2.4. Төсвийн зарлагын хэмжээг орлогын тогтвортой эх үүсвэр болон эдийн засгийн өсөлттэй уялдуулж, аливаа үргүй зардлыг хязгаарлан, төсвийн зарлагыг суурь хэмжээнд нь хүртэл бууруулах эхний алхам хийх.

2.5. Улсын төсвөөс үзүүлж буй нийтийг хамарсан нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгийн үндсэн зорилгыг хадгалж, түүнийг нийгмийн зорилтот бүлгүүд болон нийгмийн халамж хүртэх шаардлагатай хэсэгт чиглүүлж, үр дүнтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

2.6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн хямралт байдлыг даван туулахад гол түлхэц үзүүлэх, богино хугацаанд үр дүнгээ өгөх хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээнд чиглүүлэх.

2.7. Дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, санхүүжилтийн үр дүнг сайжруулах.

2.8. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын зарим ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхайн салбараас улсын төсөвт тогтвортой, өндөр орлого орох урт хугацааны үндсийг бүрдүүлэх.

2.9. Эдийн засгийн өсөлт, мөнгө, санхүүгийн бодлогын уялдааг хангаж, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэн санхүүгийн хүндрэлийг даван туулах мөнгөн хуримтлалыг өсгөх.

2.10. Монгол Улсын ээлжит зээлжих зэрэглэл буурч болзошгүй байгаа сөрөг хандлагыг зогсоож, улмаар зэрэглэлийг ахиулах эдийн засаг, санхүүгийн цогц арга хэмжээ авч эхлэх.

2.11.Санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалж, хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

2.12. Олон улсын санхүүгийн зах зээлд бонд арилжаалж, бондын эрсдэлийг удирдан, Монгол Улсын жишиг хүүг тогтоох чиглэл баримтлах.

2.13. Татварын тэгш, шударга байх зарчмыг тууштай баримталж, татварын орлогын баазыг өргөтгөн, орлогыг бүрэн хураах удирдлага, бүртгэл, тооцоо, мэдээллийн тогтолцоог сайжруулах.

2.14.Төсөв, санхүүгийн хямралт байдлыг дэс дараатай даван туулах шаардлагатай уялдуулан эдийн засагт өрийн дарамт учруулахгүйгээр гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн хэмжээг уян хатан нэмэгдүүлж, зээл, тусламжийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглах хяналт, зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх.

2.15. Санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөн, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн бүртгэл, мэдээлэл, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

2.16. Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчныг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх.

2.17. 2009 оны татварын орлогын байдлыг харгалзан төсөвт тодотгол хийж, төсвийн урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зохицуулах.

2.18.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан улс төрийн намуудын амлалтуудыг төсөвт үе шаттайгаар тусгаж, хэрэгжүүлэх.

**Гурав. Бодит салбарын хөгжлийг дэмжиж, Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлого баримтална.**

3.1.Уул уурхайн болон газрын тосны салбарын орлогоос хуримтлал бий болгож, улсын төсвийн тусгай санд төвлөрүүлэн, мэдлэгт суурилсан эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

3.2. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжиж, сүү, мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах чиглэлд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

3.3. Бүс нутгийн дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан авто зам, төмөр замын сүлжээг хөгжүүлэх бодлого баримтлах.

3.4.Түүхий эдийн нөөцөд түшиглэн цемент, арматур төмөр хийц, шил зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлж эхлэх.

3.5.Түлш, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх.

3.6.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах.

3.7.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, "Атрын 3 дахь аян"-ыг үргэлжлүүлж, техник, технологийн шинэчлэл хийх шаталсан арга хэмжээ авах;

3.8. Өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий хувийн хэвшилд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг татварын болон урамшууллын бодлогоор дэмжин хөгжүүлэх.

3.9. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн экспортын болон импортыг орлох бүтээгдэхүүний үйлвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн төрөлжилтийг сайжруулах.

3.10. Хүнд үйлдвэрийг хөгжүүлж, гидрометаллурги, катодын зэсийн үйлдвэрлэл, алт хайлуулах, кокс-химийн, хар металлургийн аж үйлдвэрийн цогцолбор барьж байгуулахыг бодлогоор дэмжих.

3.11. Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажлыг эхлэх, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж эхлэх бодлого баримтлах.

3.12. Говийн /Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр/ бүс нутгийг цогц хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын ордод түшиглүүлэн уул уурхай-металлурги-эрчим хүчний цогцолборыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

3.13. Эрчим хүчний төрөл бүрийн эх үүсгүүрийг ашиглан нийт сумыг байнгын цахилгаан эрчим хүчтэй болгох бодлого баримтлах.

3.14. Худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүдийг байгуулах бодлогыг шинэчилж, эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.

3.15. Шуудангийн салбарт Зип кодыг улс орны хэмжээнд бүрэн нэвтрүүлэх.

3.16. Нийслэл хотын дэд бүтцийг шинэчлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.

3.17. Нийслэлд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн дэд бүтэц бүхий газруудыг зөвхөн дуудлага худалдаагаар худалдаж, орлогоор нь дэд бүтцийн хөгжлийн сан байгуулж, шинээр дэд бүтцийг бий болгоход зарцуулах.

**Дөрөв. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөхиүлэн дэмжинэ.**

4.1. Геологи, уул уурхайн салбарын бодлогыг хариуцлагатай уул уурхайн зарчимд тулгуурлан шинэчлэн тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

4.2. Экологийн хувьд эмзэг, хамгаалалт шаардагдах ойн болон гол, мөрний эх, сав газраас бусад бүс нутгуудад ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор зохицуулах.

4.3. Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх эрх зүйн орчныг сайжруулж, нөхөн сэргээлтийн чанарыг дээшлүүлэх иж бүрэн механизмыг бий болгох.

4.4. Хот, суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс байгуулах ажлыг бодлогоор дэмжих.

**Тав. Иргэдээ эрүүл чийрэг, боловсролтой, ажил, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.**

5.1.Хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд, хүртээмжтэй хангах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, "Эрүүл эхээс эрүүл хүүхэд" зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулах.

5.2.Шинэ болон дахин сэргэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, түүнийг аймаг, дүүргийн түвшинд өргөжүүлэх.

5.3.Бүх нийтийн боловсролыг хөгжүүлж, үндэсний боловсролыг олон улсын түвшинд ойртуулах, оюунжсан, бүтээлч, чадамжтай, эрүүл чийрэг хүний нөөцийг байнга нэмэгдүүлэх.

5.4.Хувилбарт сургалтын төрөл, хэлбэрийг олшруулж сайжруулах замаар сургуулийн өмнөх боловсролын сургалтын хамрах түвшинг дээшлүүлэх.

5.5.Зах зээлийн өнөөгийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

5.6.Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдлийн түвшинг 2010-2012 онд 2.7-2.5 хувьд хүргэж бууруулах.

5.7.Малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аж ахуйгаа тогтвортой эрхлэх, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн үйлчилгээг өргөжүүлж, албан секторт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх.

5.8.Тэтгэврийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгон зах зээлийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх.

5.9.Малчин, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх.

5.10. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх.

**Зургаа. Төрийн үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулна.**

6.1.Төрийн удирдлагын ил тод, цомхон, чадварлаг, шуурхай байдлыг хангаж, төр, иргэний хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бэхжүүлэх.

6.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах.

6.3.Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжид төрийн бус байгууллагууд, олон нийт, иргэдийн зүгээс тавих хяналтын тогтолцоог сайжруулах.

6.4.Төрийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгож, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

6.5.Төсвийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр** **Дугаар 43** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2004 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам"-ын Хоёрын 2.1 дэх заалтын "9 дүгээр сарын 1-ний" гэснийг "4 дүгээр сарын 1-ний" гэж, 2.2 дахь заалтын "9 дүгээр сарын 20-ны" гэснийг "4 дүгээр сарын 20-ны" гэж, 2.3 дахь заалтын "10 дугаар сарын 1-ний" гэснийг "5 дугаар сарын 1-ний" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2009 оны 06 дугаар сарын 19-ний өдөр** **Дугаар 44** **Улаанбаатар хот**

**Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай**

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тогтоосугай.

2.Монгол Улсад 2009-2012 онд жил бүр оруулж болох цагаач гадаадын иргэдийн бүтцийг доор дурдсанаар тогтоосугай:

1/ Оросын Холбооны Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

2/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

3/ бусад орны харьяат иргэн 40-өөс дээшгүй.

3. Монгол Улсад 2009-2012 онд жил бүр оруулж болох цагаач гадаадын иргэдийн оршин суух байршлыг доор дурдсанаар тогтоосугай:

1/ Улаанбаатар хотод 50-иас дээшгүй;

2/ Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Дорнод аймагт тус тус 4-өөс дээшгүй;

3/ бусад аймагт 2-оос дээшгүй.

/Гэр бүлээрээ ирсэн цагаач гадаадын иргэдийг хамт байршуулах үүднээс энэ тогтоолын 3 дахь заалтын хязгаарлалтыг тэдгээрт хамааруулахгүй байж болно./

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

### Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралтаар батлсугай.

2."Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого (цаашид "бодлого" гэх)-ын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

1.2.Цөмийн энергийн салбар нь оюуны багтаамж ихтэй, өндөр технологи бүхий, сүүлийн үед дэлхий дахинаа эрчимтэй хөгжиж байгаа чиглэл бөгөөд цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүч ашиглах нь Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах, ард түмний аж байдлыг дээшлүүлэх, өртөг багатай цахилгаан, дулаан үйлдвэрлэх зорилтод хүрэх чухал хүчин зүйл болно.

1.3.Энэхүү бодлого нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах, цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг өсгөх, олборлолт, боловсруулалтыг нэмэгдүүлэх стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрийн үндэс болох бөгөөд "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ын бүрэлдэхүүн хэсэг болж хэрэгжинэ.

1.4.Бодлогыг хэрэгжүүлэхдээ улс орныхоо стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг Монголд буй болгох бодлого баримтална.

### Хоёр. Бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зарчим

2.1.Бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

2.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд харшлахгүй байх;

2.1.2.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаа нь Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх;

2.1.3.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагааг олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу зөвхөн энхийн зорилгоор явуулах;

2.1.4.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд олон улсын болон үндэсний стандартыг чанд мөрдөх;

2.1.5.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй техник, технологи хэрэглэх.

**Гурав. Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт**

3.1.Судалгаа, эрэл, хайгуул:

3.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуулын ажлыг Засгийн газрын хяналт, зохицуулалтын дагуу гүйцэтгэнэ.

3.1.2.цацраг идэвхт ашигт малтмалын бүсчилсэн болон сэдэвчилсэн судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр, эрэл, хайгуулын ажлыг улсын төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх бөгөөд тэдгээрийн мэдээллийг Монгол Улсын Үндэсний геологийн мэдээллийн санд бүртгэнэ.

3.1.3.цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуулын ажиллагаанд дотоод, гадаадын төрийн өмчийн оролцоотой болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу оролцуулна.

3.1.4.цацраг идэвхт ашигт малтмал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засагт онцгой ач холбогдолтойг харгалзан цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулна.

3.1.5.цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул болон цөмийн судалгаа, цөмийн болон цацрагийн хяналтын мэргэжилтэн бэлтгэх, давтан мэргэшүүлэх, техник технологи, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, хяналтын техникийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр орчин үеийн тэргүүний техник технологи бүхий улс оронтой хамтран ажиллана.

**3.2. Олборлолт, боловсруулалт, баяжуулалт, тээвэрлэлт:**

3.2.1.цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах, баяжуулах, цаашид цөмийн түлшний үйлдвэр байгуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.2.нөөц нь тогтоогдсон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглахад төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын адилаар тогтооно.

3.2.3.цацраг идэвхт ашигт малтмалын ордыг дагалдагч ашигт малтмалын хамт цогц байдлаар бүрэн ашиглах бодлого баримтална.

3.2.4.цацраг идэвхт агуулга өндөртэй нүүрс, нүүрсний үнс, фосфорит болон бусад ашигт малтмалаас дэвшилтэт техник технологи хэрэглэн цацраг идэвхт элементийг ялгаж ашиглана.

3.2.5.цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх бодлого баримтална.

3.2.6.цацраг идэвхт ашигт малтмалаас гаргаж авсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын болон олон улсын гэрээнд нийцүүлэн гагцхүү энхийн зориулалтаар экспортлоно.

3.2.7.цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах, ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох, тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн хяналтан дор явуулна.

**3.3.Ашиглах нөхцөл:**

3.3.1.цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглах үйл ажиллагаанд энэхүү бодлогын 3.3.2-т заасан хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан дотоод, гадаадын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нийцсэн урт хугацааны гэрээ байгуулан, хамтран ажиллах бодлого баримтална.

3.3.2.стратегийн хөрөнгө оруулагч нь дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байвал зохино:

3.3.2.1.ерөнхий нөхцөл:

а/энэхүү бодлогын 1.4-т заасан нөлөө бүхий улстай харьцах тухай бодлого зарчимд нийцсэн;

б/Монгол Улсын нутаг дэвсгэрт олборлосон цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан;

в/цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийг хийх санхүүгийн чадавхтай;

г/цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн;

д/үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй.

3.3.2.2.техник технологийн хувьд:

а/цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай;

б/цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой;

в/цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай;

г/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашигладаг.

3.3.2.3.байгаль орчин, аюулгүй ажиллагааны хувьд:

а/хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар туршлага хуримтлуулсан;

б/уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг;

в/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг явуулж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийдэг.

3.3.2.4.нийгмийн асуудлаар:

а/бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог;

б/ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай;

в/компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн.

**Дөрөв.Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагаа**

4.1.Монгол Улсын эрчим хүчний хангамж, баланс, экспортлох боломжтой уялдуулан цөмийн эрчим хүчний гүйцэтгэх үүрэг оролцоог тооцоолж, цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан барьж байгуулах ажлыг ойрын 10 жилийн дотор эхлүүлэх чиглэлийг баримтална.

4.2. Цөмийн эрчим хүч ашиглахад шаардлагатай дэд бүтцийг тухайн төсөлд багтаах буюу бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авч, Монгол Улсын дэд бүтцийн нэгдсэн хөтөлбөрүүдтэй уялдуулна.

4.3. Цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх явцад олсон ололт амжилтыг эрчим хүч, аж үйлдвэр, геологи, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, судалгаа, эрдэм шинжилгээ болон бусад салбарт нэвтрүүлэх арга хэмжээг тууштай дэмжиж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.4. Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглахад шаардлагатай цөмийн түлшийг импортлох, хил дамжуулан тээвэрлэх, өөрийн нутаг дэвсгэрт хадгалах нөхцөлөөр хангана.

4.5. Гадаад орнуудын туршлага судлах замаар цөмийн болон цацраг идэвхт хаягдлын хадгалалт, булшлалт, боловсруулалт зэрэг нарийн хяналт, өндөр технологи шаардсан үйл ажиллагааг өөрийн оронд хэрэгжүүлэх чиглэл баримтална.

4.6.Цөмийн энергийн талаар баримтлах бодлого олон нийт болон хөрш орнуудад нээлттэй байна.

**Тав.Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа**

5.1.Цөмийн болон цацрагийн аюулгүй байдалд хяналт тавих үндэсний дэд бүтэц, хяналтын тогтолцоог олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авна.

5.2.Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хадгалах, цөмийн хаягдлыг боловсруулах байгууламжийн хамгаалалтыг боловсронгуй болгох, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах, цөмийн байгууламж, үйлдвэрийг барьж байгуулахад хамгаалалтын тогтолцоог урьдчилан тооцоолох үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлнэ.

5.3.Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт изотоп, цөмийн болон цацраг идэвхт хаягдлын биет хамгаалалтын найдвартай байдлыг хангана.

5.4.Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангаж, мэдээллийн нэгдсэн сан, бүртгэлийн тогтолцоог бий болгож, олон улсын холбогдох байгууллагад шаардлагатай мэдээллийг хугацаанд нь мэдээлнэ.

5.5.Цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаа явуулах салбарт чанарын хяналтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.6.Цөмийн болон цацрагийн болзошгүй ослын бэлэн байдал, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний үндэсний хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ.

**Зургаа. Эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, хүний нөөц**

6.1.Цөмийн энерги, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, шинжилгээ, технологи боловсруулалт, практик хэрэгцээг хангахад чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоож хэрэгжүүлнэ.

6.2.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн судалгаа, технологийн чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, бизнесийн салбарын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангана.

6.3.Цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалт, цөмийн эрчим хүчний эх үүсвэр, өндөр технологийн судалгаа

явуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэргэжилтнийг дадлагажуулан сургах үйл ажиллагааг хариуцах Цөмийн судалгаа, технологийн үндэсний хүрээлэнг байгуулж ажиллуулна.

6.4.Цөмийн судалгаа, технологийн үндэсний хүрээлэн нь цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн физикийн салбарт шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хийх суурь, хавсарга судалгаа, боловсруулалтын үйл ажиллагааг бусад эрдэм шинжилгээний байгууллага, их сургуультай хамтран эрхлэн явуулна.

6.5. Цөмийн физикийн суурь болон хавсарга судалгаа явуулах, өндөр технологи боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх зорилгоор цөмийн судалгааны реактортой болох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

6.6. Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энерги, өндөр технологийн чиглэлээр үндэсний мэргэжилтнийг тусгай хөтөлбөрийн дагуу бусад оронд бэлтгэнэ.

6.7. Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн салбар дахь олон улсын болон гадаадын байгууллага, төсөл хөтөлбөрт хамрагдах үндэсний эрдэмтэн, мэргэжилтний оролцоог нэмэгдүүлнэ.

**Долоо. Эрх зүйн орчин**

7.1. Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахтай холбогдсон техник, технологи, аюулгүй байдал, хамгаалалт, баталгаа, хариуцлага, эрх, үүрэг болон цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ.

7.2. Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалт, цөмийн эрчим хүч ашиглах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлнэ.

7.3. Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалт, цөмийн энерги ашиглах явцад учирч болох эрсдэл, түүнийг даван туулах үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

7.4.Цөмийн болон цацрагийн аюулгүй байдалтай холбогдсон олон улсын гэрээ, конвенци, хэлэлцээр, протоколын биелэлтийг хангах, шаардлагатай гэрээ, конвенцид нэгдэн орох асуудлыг шийдвэрлэнэ.

**Найм. Салбарын удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаа**

8.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, бизнесийн үйл ажиллагааг эрхлэх удирдлага, зохион байгуулалт нь харилцан уялдаатай, бие даасан бүтэцтэй байна.

8.2. Монгол Улсад цөмийн энерги ашиглах, цөмийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, бүрдүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал, хяналтын цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх үүрэг бүхий цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

8.3. Цөмийн энерги, цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглах, уурхайн орчныг нөхөн сэргээх болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, хяналт, судалгаа, сургалтын талаар бусад орон, олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

8.4. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

8.5. Цөмийн энергийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах ажлыг оновчтой, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот |

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 55 дугаар тогтоолын 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын "Петровис" ХХК-ийн ерөнхий захирал" гэснийг "Мобиком" корпорацийн ерөнхий захирал" гэж, "Скайтел" ХХК-ийн ерөнхий захирал" гэснийг "Тайж трейд" ХХК-ийн ерөнхий захирал" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

### Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

1/ Монголбанкны Дэд ерөнхийлөгч;

2/ Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөх;

3/ Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

4/ Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга;

5/ Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх;

6/ Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Үндэсний статистикийн газрын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 03-ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

### Кувейт Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай

Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг Үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ :

Кувейт Улсын нийслэл Эль-Кувейт хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 09-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

### Комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Комиссын дарга:**

Х.Жекей - Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга

**Орлогч дарга:**

Г.Баясгалан - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

**Нарийн бичгийн дарга:**

Д.Батжаргал - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга

Гишүүдэд:

Д.Загджав - Улсын Их Хурлын гишүүн

Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн

Д.Батсайхан - Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч

Ч.Мөнхбат - Улсын ерөнхий прокурорын орлогч

Б.Баатарзориг - Нийслэлийн Засаг даргын орлогч

Б.Пүрэвням - Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч

Г.Аюурзана - Ерөнхийлөгчийн Тамгын газрын уучлал хариуцсан референт

С.Ганбат - Эрүүгийн цагдаагийн газрын дарга

2. Өршөөл үзүүлэх ажлын дүнг 2009 оны 8 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулахыг Комисс / Х.Жекей /-т даалгасугай.

3.Цагдан хорих төв, хорих анги болон баривчлах байрнаас суллагдсан хүмүүсийг орон нутагт хүргэх болон өршөөл үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолыг 2009 оны 7 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 126 | Улаанбаатар хот

### Дорноговь аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Дорноговь аймгийн харьяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Сайншанд сум**

1. Ансалмаагийн Баярмаа - Гэрийн ажилтай

**Улаанбадрах сум**

2. Должингийн Цэгмэд - Гэрийн ажилтай

**Хатанбулаг сум**

3. Чимэдсүрэнгийн Мөнгөнтунгалаг - Халив багийн малчин

**"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Айраг сум**

1. Цэрэнгийн Алдармаа - Гэрийн ажилтай
2. Дарьсүрэнгийн Бямбасүрэн - Гэрийн ажилтай
3. Дамдинсүрэнгийн Должинсүрэн - Гэрийн ажилтай
4. Цэдэнсодномын Дэлгэрзаяа - Гэрийн ажилтай
5. Жамсрангийн Саранчимэг - Гэрийн ажилтай

**Алтанширээ сум**

6. Даваагийн Нарангарав - Гэрийн ажилтай
7. Содномын Энхцэцэг - Тойг багийн малчин

**Даланжаргалан сум**

8. Дондогсүрэнгийн Баасантуяа - Гэрийн ажилтай

**Дэлгэрэх сум**

9. Наваантаягийн Цэрэнлхам - Гэрийн ажилтай
10. Гончигийн Цэцэгбадам - Гэрийн ажилтай

**Замын-Үүд сум**

11. Мажигийн Амаржаргал - Төмөр замын 11 дүгээр хэсгийн замчин
12. Ринагийн Амрийда - Гэрийн ажилтай
13. Жамбалын Буянжаргал - Гэрийн ажилтай
14. Хандсүрэнгийн Гангаамаа - Гэрийн ажилтай
15. Дэндэвийн Нансалмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
16. Дамдинсүрэнгийн Уранчимэг - Төмөр замын 4 дүгээр хэсгийн замчин

**Иххэт сум**

17. Шураагийн Ариунчимэг - Гэрийн ажилтай

**Мандах сум**

18. Дашнямын Уранчимэг - 3 дугаар багийн малчин
19. Чулуун-Арслангийн Янжинхорол - 2 дугаар багийн малчин

**Сайншанд сум**

20. Цэрэнжавын Гантулга - Гэрийн ажилтай
21. Чойлдонгийн Дулам - Гэрийн ажилтай
22. Бат-Очирын Мөнгөнсар - Гэрийн ажилтай
23. Самбуугийн Уранчимэг - Гэрийн ажилтай
24. Бямбаагийн Эрдэнэчимэг - Гэрийн ажилтай

**Сайхандулаан сум**

25. Мөнхтогтохын Батдэлгэр - "Салхит 3 өндөр" ХХК-ийн худалдагч

**Хатанбулаг сум**

26. Хорлоогийн Алтанцэцэг - Агаруут багийн малчин
27. Ёнгойн Нямхүү - 2 дугаар багийн малчин
28. Монхдойн Түмэндэмбэрэл - Гэрийн ажилтай

**Эрдэнэ сум**

29. Ренцэнгийн Анхтуяа - Мянганы замын ажилчин
30. Дамбалайн Пүрэвдаваа - Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн ажилчин

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 127 | Улаанбаатар хот

### Дорнод аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Дорнод аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

### "АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

**Баян-Уул сум**

1. Осгоны Алтангэрэл - Гэрийн ажилтай
2. Цагаанхүүгийн Дарьжав - Гэрийн ажилтай

**Цагаан-Овоо сум**

3. Өлзийгийн Гантуяа - 3 дугаар багийн малчин

**Чойбалсан сум**

4. Нямын Мөнхтуяа - ЕБС-ийн үйлчлэгч

**Хөлөнбуйр сум**

5. Шаравын Цагаачин - Гэрийн ажилтай

**Хэрлэн сум**

6. Лувсаншаравын Наянтай - Гэрийн ажилтай
7. Шугарын Орших - Гэрийн ажилтай
8. Түгжийн Энхцэцэг - Гэрийн ажилтай

### "АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

**Баяндун сум**

1. Жамсрангийн Хандсүрэн - 4 дүгээр багийн малчин
2. Өлзийгийн Эрдэнэцэцэг - Малчин

**Баян-Уул сум**

3. Гонгоржавын Бадамцэцэг - Гэрийн ажилтай
4. Дугарын Бурмаа - Гэрийн ажилтай
5. Раднаагийн Наранцэцэг - Гэрийн ажилтай
6. Дугарын Удвал - Гэрийн ажилтай
7. Цэвээний Уранбилэг - Гэрийн ажилтай

**Гурванзагал сум**

8. Дамдинсүрэнгийн Жавзандулам -ЕБС-ийн үйлчлэгч
9. Дамдингийн Хоролсүрэн - Гэрийн ажилтай

**Дашбалбар сум**

10. Дамдиндоржийн Байгал - Малчин
11. Дамдины Оюунцэцэг -Хүн эмнэлэгт асрагч

**Матад сум**

12. Баатарын Ганганцэцэг - Гэрийн ажилтай
13. Намсрайн Ундаръяа - Гэрийн ажилтай

**Цагаан-Овоо сум**

14. Цэрэнжавын Дарь - Гэрийн ажилтай
15. Даржмаагийн Намжилмаа - Гэрийн ажилтай
16. Мэдэгмаагийн Нямсүрэн - Малчин
17. Хорлоогийн Энхцэцэг - Малчин

**Чойбалсан сум**

18. Мажигийн Оюун-Эрдэнэ - Малчин
19. Жамъянсүрэнгийн Цэцэгмаа - Гэрийн ажилтай

**Чулуунхороот сум**

20. Пүрэвдоржийн Баярмаа - Галуут багийн малчин
21. Гантөмөрийн Оюунтүлхүүр - Гэрийн ажилтай

**Халхгол сум**

22. Цэрэндашийн Туяа - ЕБС-ийн тогооч
23. Эрвээхэйн Цэрэндэжид - Гэрийн ажилтай

**Хөлөнбуйр сум**

24. Бүрэгдээгийн Алтан-Эрх - Гэрийн ажилтай
25. Түнтээний Баян - Гэрийн ажилтай

**Хэрлэн сум**

26. Гомбодоржийн Алтанзагас - 2 дугаар багийн малчин
27. Цэрэнгийн Байгалмаа - Гэрийн ажилтай
28. Хаянхярваагийн Баясгалан - Гэрийн ажилтай
29. Ганболдын Болормаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
30. Долгорсүрэнгийн Бямбасүрэн - Гэрийн ажилтай
31. Шагдарын Гарамцоо - Гэрийн ажилтай
32. Баатарын Дашцэцэг - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн асрагч
33. Мажигийн Долгорсүрэн - 2 дугаар цэцэрлэгийн тогооч
34. Мажигсүрэнгийн Долгорсүрэн - Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн бичиг хэрэг, архивын ажилтан
35. Данзангийн Жавзмаа - Гэрийн ажилтай
36. Тогтохын Жиргэрсүрэн -1 дүгээр багийн малчин
37. Чойнхорын Ичинхорлоо - Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэгийн Дорнод салбарын дарга
38. Гантөмөрийн Мөнхзул - Гэрийн ажилтай
39. Лочингийн Мөнхцэцэг - Гэрийн ажилтай
40. Балдангийн Мягмар - Гэрийн ажилтай
41. Доржпаламын Одгэрэл - Гэрийн ажилтай
42. Шараагийн Оюунсайхан - Гэрийн ажилтай
43. Данзанравжаагийн Оюунцэцэг - Гэрийн ажилтай
44. Дансрангийн Оюунцэцэг - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн сувилагч

45. Уранчимэгийн Сосорбарам - Гэрийн ажилтай
46. Должингийн Тогтох - Гэрийн ажилтай
47. Доржийн Төмөрсүх - Гэрийн ажилтай
48. Доржнамжилын Уламбаяр - Гэрийн ажилтай
49. Гэндэнжамцын Ханддолгор - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн асрагч
50. Бямбын Цэнд-Аюуш - Гэрийн ажилтай
51. Болдын Цэндэнханд - Гэрийн ажилтай
52. Готовын Цэрэнбалжир - Гэрийн ажилтай
53. Лутаагийн Цэцэгмаа - Гэрийн ажилтай
54. Рагчаагийн Цэцэгмаа - Гэрийн ажилтай
55. Шаравжамцын Чимгээ - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн сувилагч
56. Гансүхийн Шижиртуяа - Гэрийн ажилтай
57. Лувсаншаравын Энхзаяа - Гэрийн ажилтай
58. Гунаажавын Энхсайхан - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн асрагч
59. Ванчинсүрэнгийн Энхтайван - Гэрийн ажилтай
60. Маналжавын Энхээ - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 128** | **Улаанбаатар хот**

**Дундговь аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Дундговь аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Гурвансайхан сум**

1. Лувсандоржийн Гарам - Дэрсэнэ-Ус багийн малчин

**Дэрэн сум**

2. Готовын Эрдэнэчимэг - 2 дугаар багийн малчин

**"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Адаацаг сум**

1. Дашпэлжээгийн Чимэдлхам -1 дүгээр багийн малчин
2. Жагзмаагийн Эрдэнэчимэг -1 дүгээр багийн малчин

**Баянжаргалан сум**

3. Сосорын Готов - 1 дүгээр багийн малчин

**Говь-Угтаал сум**

4. Сэрээтэрийн Пүрэвсүрэн - Дунд сургуулийн багш

**Гурвансайхан сум**

5. Дамчаагийн Даваажав - Дэрсэнэ-Ус багийн малчин

**Дэлгэрхангай**

6. Норовын Мөнхцэцэг - 2 дугаар багийн малчин

**Дэрэн сум**

7. Должинсүрэнгийн Гантөмөр - 1 дүгээр багийн малчин
8. Дашцэрэнгийн Сугирмаа - 3 дугаар багийн малчин
9. Ядамын Цэцэг - 3 дугаар багийн малчин

**Луус сум**

10. Нэргүйн Тунгалагцэцэг - Суврага багийн малчин

**Өндөршил сум**

11. Дэлгэрсуурийн Одгэрэл - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
12. Дарьмаагийн Сумъяа - Малчин

**Сайхан-Овоо сум**

13. Чагнаагийн Юмчмаа - 4 дүгээр багийн малчин

**Сайнцагаан сум**

14. Арилдийн Алимаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
15. Лувсанчойн Батнасан - Гэрийн ажилтай
16. Цэрэнпилийн Долгорсүрэн - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
17. Гүрхэний Лхамжав - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
18. Нанжидын Мөнхсайхан - Хайрхан ХХК-д худалдагч
19. Лувсандоржийн Отгонжаргал - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
20. Цэдэндоржийн Цэрэнпилсүрэн - Тэвш багийн малчин

**Эрдэнэдалай сум**

21. Рэнчиндоржийн Алдармаа - 6 дугаар багт малчин
22. Гочигсүрэнгийн Нарантуяа - 4 дүгээр багийн малчин
23. Мөнхчулууны Наранчимэг - 4 дүгээр багийн малчин

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 129 | Улаанбаатар хот

### Завхан аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Завхан аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Отгон сум**
1. Жалбуужавын Сумъяа - Малчин

**Тосонцэнгэл сум**
2. Шагдарын Ренчинханд - Гэрийн ажилтай

**Тэлмэн сум**
3. Доохуугийн Чанцалмаа - Гэрийн ажилтай

**Улиастай сум**
4. Нямренчингийн Базарсүрэн - Гэрийн ажилтай
5. Мөнхөөгийн Мөнхжаргал - Гэрийн ажилтай

**Яруу сум**
6. Ягааны Наранцацрал - Малчин

**"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Алдархаан сум**
1. Дамдинжавын Бямбаа - Малчин
2. Баагуузын Хандсүрэн - Малчин

**Баянтэс сум**
3. Ханддоржийн Мөнхжаргал - Малчин
4. Банзрагчийн Сампилноров - Малчин
5. Циенрэгзэнгийн Цэнд-Аюуш - Гэрийн ажилтай

**Дөрвөлжин сум**
6. Сурмаажавын Байгальмаа - ЗДТГ-ын бичиг хэрэг хөтлөгч
7. Түдэвийн Чимэдрэгзэн - Группэд

**Завханмандал сум**
8. Бавуужавын Рэгзэдмаа - Малчин

**Их-Уул сум**
9. Баасандашийн Амаржаргал - Малчин
10. Цогзолын Бадамгарав - Малчин
11. Цэрэннадмидын Батжаргал - Малчин
12. Пагамын Батцэнгэл - Малчин
13. Түвдэнгийн Гэрэлмаа - Малчин
14. Эрдэнэбатын Ичинхорлоо - Малчин
15. Ренчингийн Чимэдрэгзэн - Малчин
16. Бадамын Туяа - Малчин
17. Цэрэнпүрэвийн Эрдэнэцогт - Малчин

**Нөмрөг сум**
18. Чойжилсүрэнгийн Мягмарцэрэн - Малчин

**Отгон сум**
19. Батбямбын Байгальмаа - Малчин
20. Дашбалын Бархас - Хүүхдийн цэцэрлэгийн үйлчлэгч
21. Пүрэвдоржийн Дэлгэрмаа - Малчин
22. Равдангийн Жавзандулам - Малчин
23. Пүрвээгийн Лхамсүрэн - Малчин
24. Норовванжилын Нямсүрэн - Малчин
25. Чанцалын Отгонсүрэн - Хүн эмнэлгийн үйлчлэгч
26. Бямбабазарын Чимгээ - Малчин
27. Батдоржийн Энх-Амгалан - Малчин

**Сантмаргац сум**
28. Нанжидын Сүрэнхүү - Малчин
29. Онгойн Тогтохбаяр - Малчин
30. Вандансамбуугийн Цацрал - Малчин

**Сонгино сум**
31. Мижиддоржийн Оюунжаргал - Малчин
32. Ягааны Пампаргаа - Малчин

**Тосонцэнгэл сум**
33. Норовсамбуугийн Авирмэд - Гэрийн ажилтай
34. Зэдрагчаагийн Баяржаргал - Гэрийн ажилтай
35. Бямбажавын Долгорсүрэн - Гэрийн ажилтай
36. Энхтуяагийн Долгорсүрэн - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
37. Дондовын Отгонбаяр - Гэрийн ажилтай
38. Жамбын Оюунсайхан - Гэрийн ажилтай

**Түдэвтэй сум**
39. Чулууны Гэрэлчимэг - Гэрийн ажилтай
40. Цэрмаагийн Циенхорлоо - Гэрийн ажилтай

**Тэлмэн сум**
41. Гүсэнжавын Должинсүрэн - Эмийн санч
42. Хайнзангийн Нямхүү - Малчин

**Тэс сум**
43. Чадраагийн Батнасан - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
44. Цэрэндоржийн Батсүмбэр - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
45. Оноогийн Ганбилэг - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
46. Цэсүрэнгийн Түмэнжаргал - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

**Улиастай сум**
47. Дашдаваагийн Баасанжав - Гэрийн ажилтай

48. Дарамжавын Ваня - Гэрийн ажилтай
49. Туваансүрэнгийн Гантуяа - Гэрийн ажилтай
50. Намхайдавгын Намжилмаа - Гэрийн ажилтай
51. Нанжидын Очирсүрэн - Гэрийн ажилтай
52. Даваасамбуугийн Сарантуяа - "Дэвшил" сургуулийн багш
53. Магвандоржийн Уранчимэг - Гэрийн ажилтай
54. Дашмаагийн Цэрэндолгор - Гэрийн ажилтай

**Ургамал сум**

55. Норовын Хажидмаа - Малчин

**Цэцэн-Уул**

56. Мягмаржавын Машбаяр - Малчин
57. Амаржаргалын Ууганбаяр - Малчин
58. Нацагийн Цэрмаа -Малчин

**Шилүүстэй сум**

59. Шагдарын Бямбажав - Малчин
60. Цэрэнжигмэдийн Долгорсүрэн - Малчин
61. Довжидын Насандэлгэр - Малчин
62. Бэгзсүрэнгийн Норжмаа - Малчин
63. Дүгэрхоролын Нямдорж - ЗДТГ-ын ХХАА-н байцаагч
64. Сандагаагийн Оюунчулуун - Малчин

**Яруу сум**

65. Даваасамбуугийн Долгормаа - Гэрийн ажилтай
66. Дашдондовын Оюун - Гэрийн ажилтай
67. Дашдүгэрийн Сэндсүрэн - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 130** **Улаанбаатар хот**

**Орхон аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Орхон аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

### "АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

1. Пунцагдашийн Ганчимэг - Гэрийн ажилтай
2. Түмэнгийн Жавзан - Малчин
3. Дашдоржийн Пагма - Гэрийн ажилтай
4. Зэвгээгийн Пунсал - Гэрийн ажилтай
5. Цагаачийн Цолмонтуяа - Улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн жижүүр
6. Намдагийн Чойжав - Гэрийн ажилтай

### "АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

1. Самбуугийн Амгалан - Гэрийн ажилтай
2. Доржийн Бадамхүү - Гэрийн ажилтай
3. Махбалын Баярмаа - Малчин
4. Шагдарсүрэнгийн Буянхишиг - "Очир төв" ХХК-д засал чимэглэлч
5. Зундуйдоржийн Даваажаргал - Гэрийн ажилтай
6. Ядамын Зандармаа - Гэрийн ажилтай
7. Тугелбайн Кулия - "Жани" ХХК-ийн захирал
8. Долгорын Мөнхжаргал - Гэрийн ажилтай
9. Лхамжавын Нарангэрэл - Гэрийн ажилтай
10. Бадамваанчигийн Наранцэцэг - Гэрийн ажилтай
11. Очирбатын Насанцэцэг -Гэрийн ажилтай
12. Эрхэмбаярын Нямсүрэн -Гэрийн ажилтай
13. Бямбаагийн Одончимэг - Гэрийн ажилтай
14. Чойжилсүрэнгийн Сарантуяа - Улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн оёдлын цехийн дарга
15. Мягмарын Туяа - Улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн жижүүр
16. Дагвын Уранчимэг - Гэрийн ажилтай
17. Содномбалын Уранчимэг - Хот тохижуулах газарт байцаагч
18. Мажигийн Хишигбат - Малчин
19. Хорлоогийн Цэвээн - Гэрийн ажилтай
20. Баяртын Цэрэндулам - Гэрийн ажилтай
21. Бадарчийн Цэцгээ - Гэрийн ажилтай
22. Шаравын Эгиймаа - "Эрдэнэт хивс" ХХК-ийн нэхэгч

23. Дурмагийн Энхжаргал - Гэрийн ажилтай
24. Баасангийн Энхтайван - Улаан загалмайн хорооны ажилтан
25. Эрэвийн Энхтайван - Гэрийн ажилтай
26. Дуламжавын Энхтуяа - Гэрийн ажилтай
27. Луудайн Эрдэнэсүрэн - Гэрийн ажилтай
28. Рагчаагийн Эрдэнэшүр - Гэрийн ажилтай
29. Сономын Эрдэнэцэцэг - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2009 оны 03 дугаар сарын 18-ны өдөр** **Дугаар 72** **Улаанбаатар хот**

### Дүрэм батлах тухай

Барилгын тухай хуулийн 5.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт, "Барилга ашиглалтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Эдгээр дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 100 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАТТУЛГА**

**Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРЭМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Барилгын тухай хуулийн 3.1.4-т заасан бүх төрлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

### Хоёр. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

2.1. Шинээр болон өргөтгөж барьсан барилга байгууламжийг ашиглалтад оруулахад Техникийн болон Улсын комисс, их болон урсгал засварын ажил хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулахад Техникийн комисс дангаар ажиллана.

2.2. Улсын комисс нь Техникийн комиссын акт, дүгнэлтийг үндэслэн шинээр болон өргөтгөж барьсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана.

2.3. Их болон урсгал засварын ажил хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах акт, дүгнэлтийг Техникийн комисс дангаар гаргана.

2.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, дүгнэлтийг үндэслэн комиссын дарга бүртгэлийн дугаар олгосноор тухайн барилга байгууламж ашиглалтад орсонд тооцно.

2.5. Комисс нь энэ дүрмийн 1 дүгээр хавсралтаар баталсан дэгийн дагуу ажиллана.

### Гурав. Комиссын бүрэлдэхүүн

3.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын болон Техникийн комиссын бүрэлдэхүүнийг энэ дүрмийн 2 дугаар хавсралтын дагуу байгуулан ажиллуулна.

3.2. Барилга байгууламжийн зориулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний техник технологийн онцлогтой уялдуулан тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын төлөөллийг Улсын болон Техникийн комиссын бүрэлдэхүүнд оруулна.

### Дөрөв. Комиссын эрх, үүрэг

4.1. Улсын комисс нь дараах эрх, үүрэгтэй байна:

4.1.1. Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

4.1.2. шаардлагатай гэж үзвэл барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн тодорхой хэсэг буюу зангилаа далдлагдсан ажлаас сонгон авч задлан үзэж магадлан шалгах, мэргэжлийн шинжээч томилон судалгаа шинжилгээ, тооцоо хийлгэж дүгнэлт гаргуулах;

4.1.3. Техникийн комиссын шийдвэр нь шаардлага хангаагүй гэж үзсэн тохиолдолд Техникийн комиссыг дахин ажиллуулах;

4.1.4. Барилгын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, норм, дүрмийн заалтыг зөрчсөн гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагад хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг нь цуцлах саналыг холбогдох байгууллагад тавих;

4.1.5. барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдсон баримт бичиг, магадлагааг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах;

4.1.6. технологийн хувьд нэгдмэл бус, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт нь харилцан уялдаагүй барилга байгууламжийг ашиглалтад оруулахад Барилгын тухай хуулийн 19.1-д заасныг баримтлах;

4.1.7. комисс ажиллах үед илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгуулж, энэхүү дүрмийн 3 дугаар хавсралтаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын актыг үйлдэж, гарын үсэг зурж, баталгаажуулах;

4.2. Техникийн комисс нь дараахь эрх, үүрэгтэй байна:

4.2.1. барилга байгууламжийг шинээр барьсан, өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэсэн техникийн баримт бичгийн иж бүрдлийг хянах, ажлын гүйцэтгэл, техникийн асуудлаархи зөрчлийг арилгуулах, Улсын комисс ажиллах бэлтгэлийг хангах;

4.2.2. Техникийн комиссын гишүүн бүр өөрийн төлөөлж байгаа байгууллага, хариуцсан ажил мэргэжлийн чиглэлээр дараахь үүргийг гүйцэтгэж, саналаа комиссын хуралд танилцуулах үүрэгтэй. Үүнд:

4.2.2.1. барилга байгууламжийн угсралт, тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээний ажил нь бат бэх, найдвартай ажиллагаа, зураг төсөл, барилга техникийн болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл болон галын аюулгүй байдлын норм, дүрэм, хийц бүтээц, эдлэхүүн, материалын чанар стандарт, техникийн нөхцөлийн шаардлага хангасан эсэхийг нарийвчлан шалгах;

4.2.2.2. өргөх байгууламж, цахилгаан шат, суурилагдсан тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийгдсэн байдал, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгах;

4.2.3. барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, шинэчлэл, засварын ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн, хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлагыг зөрчсөн бол илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хүртэл Техникийн комиссыг ажиллуулахгүй байх;

4.2.4. эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээг Улсын комисс ажиллах хүртэл туршилтын журмаар түр холболт хийхийг зөвшөөрөх;

4.2.5. комиссын гишүүд нь өөрийн мэргэжлийн чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа комиссын актад гарын үсэг зурж баталгаажуулах;

4.2.6. энэхүү дүрмийн 4 дүгээр хавсралтаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах Техникийн комиссын актыг үйлдэж ашиглалтад оруулах барилга байгууламжийн баримт бичгийн бүрдэлд оруулах.

**Тав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах өөрийн төлөөллийг энэхүү дүрмийн 5 дугаар хавсралтаар баталсан Мэдэгдэлд заасан хугацаанд бэлэн байлгана.

5.2. Комисст ажиллах төлөөлөл нь комиссын үйл ажиллагаанд оролцохын өмнө ашиглалтад оруулах барилга байгууламжийн холбогдох баримт бичиг, бусад шаардлагатай материалтай урьдчилан танилцсан байна.

5.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас комисст төлөөллийг оролцуулах боломжгүй бол энэ тухай комиссын даргад албан ёсоор урьдчилан мэдэгдэнэ.

**Зургаа. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

6.1. Гүйцэтгэгч нь энэхүү дүрмийн 6 дугаар хавсралтаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулахын тулд бүрдүүлэх жишиг баримт бичгийн жагсаалтын дагуу барилга байгууламжийн ил, далд ажлын гүйцэтгэлийн актыг гэрэл зураг болон гүйцэтгэлийн зургаар баримтжуулан бүрдүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтан, гарын үсэг зурж, тэмдэг дарсан, баримт бичгийн товъёог хийсэн байна.

6.2. Барилга байгууламж барих, өргөтгөл шинэчлэл хийх, засварлах явцад мэргэжлийн хяналтын болон захиалагч, зураг төслийн байгууллагаас өгсөн албан шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргасан байна.

6.3. Анхны зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн барилга байгууламжийн төлөвлөлт, бүтээц, гадна болон дотор инженерийн шугам сүлжээний ажилд гүйцэтгэлийн зураг гаргаж, баталгаажуулан хавсаргана.

6.4. Барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх явцын барилгын Техникийн тэмдэглэл /талбайн журнал/-ийг зохих ёсоор хөтөлж захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

6.5. Барилга угсралтын ажилд ашигласан түүхий эд, материал эдлэхүүний үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, тохирлын болон техникийн гэрчилгээ, чанарын баталгааг зохих ил, далд ажлын актад хавсаргасан байна.

6.6. Ерөнхий гүйцэтгэгч нь Улсын болон Техникийн комисс ажиллах үед туслан гүйцэтгэгчдийг байлцуулна.

6.7. Гүйцэтгэгч байгууллага улсын болон Техникийн комиссын хурлаас өгсөн үүрэг

даалгаврын биелэлтийг гарган, захиалагч нь хянаж зөвшөөрсөн байна.

6.8. Улсын комисс ажиллах үед барилга байгууламжийн зураг төсөл, холбогдох баримт бичиг, актуудын бүрдлийг бэлэн байлгана.

6.9. Энэхүү дүрмийн 5 дугаар хавсралтаар баталсан Мэдэгдлийг Техникийн комисс ажиллахаас 5 хоногийн өмнө комиссын гишүүдэд хүргэсэн байна.

**Долоо. Захиалагчийн эрх, үүрэг**

7.1. Барилга угсралтын ажил иж бүрэн гүйцэтгэгдсэн үед Техникийн комиссыг, Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгавар бүрэн биелэгдсэн нөхцөлд Улсын комиссыг ажиллуулна.

7.2. Захиалагч нь улсын болон Техникийн комиссын ажиллах нөхцөлийг хангаж, гарах зардлыг хариуцан, шаардлагатай бол комисс томилсон байгууллагаас дэмжлэг туслалцааг авна.

7.3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад дахин комисс ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг захиалагч хариуцна.

7.4. Захиалагч улсын болон Техникийн комиссын хурлын тэмдэглэл хөтөлж, өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг гарган баталгаажуулна.

7.5. Захиалагч нь Улсын комисс ажиллуулах хүсэлт гаргахдаа Техникийн комиссын акт, хурлын тэмдэглэлийг өгсөн үүргийн биелэлтийн хамт мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ. Энэхүү дүрмийн 5 дугаар хавсралтаар баталсан Мэдэгдлийг Улсын комисс ажиллахаас 5 хоногийн өмнө комиссын гишүүдэд хүргэнэ.

7.6. Комисс ажиллах үед энэхүү дүрмийн 6 дугаар хавсралтаар баталсан техникийн баримт бичиг, шаардлагатай бусад материалыг бүрдүүлсэн байна. Комисс ажиллахаас өмнө захиалагч, гүйцэтгэгч нь баримт бичгийн бүрдэлд дотоодын хяналтыг хийсэн байвал зохино.

**Найм. Зураг төсөл зохиогчийн эрх, үүрэг**

8.1. Барилга байгууламжийн зураг төслийн зохиогч нь комиссын бүрэлдэхүүнд орж ажиллана.

8.2. Техникийн комисс ажиллах үед зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж, биелэлтийг хангуулсан байна.

8.3. Зураг төсөл, холбогдох норм, дүрмийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд энэ тухай хурлын тэмдэглэлд тусгаж, тэдгээрийг арилгуулах арга хэмжээ авна.

8.4. Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч байгууллага нь Улсын болон Техникийн комисс ажиллах үед зураг төслийн туслан гүйцэтгэгчийн төлөөллийг байлцуулна.

**Ес. Дулаан, цахилгаан, ус хангамж, бохир ус зайлуулах болон харилцаа холбооны шугам сүлжээний байгууллагын эрх, үүрэг**

9.1. Дулаан, цахилгаан, ус хангамж, бохир ус зайлуулах болон харилцаа холбооны шугам сүлжээний ашиглалтын байгууллага нь Комиссын бүрэлдэхүүнд өөрийн байгууллагыг төлөөлөн оролцох тухайн чиглэлийн ажил хариуцсан инженер, техникийн ажилтныг томилж, түүнийг ажиллах нөхцөл боломжоор хангана.

9.2. Энэхүү дүрмийн 9.1-д заасан байгууллагын төлөөлөл нь тухайн чиглэлийн зураг төсөл, барилга байгууламжийн угсралтын ажилтай танилцаж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж нь цаашид хэвийн найдвартай ажиллаж, ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргана.

9.3. Техникийн нөхцөл болон зураг төсөл зөрчсөн тохиолдолд энэ тухай хурлын тэмдэглэлд тусгаж, тэдгээрийг арилгуулах арга хэмжээ авна.

**Арав. Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг**

10.1. Төрийн захиргааны холбогдох байгууллага нь улсын комиссын бүрэлдэхүүнд өөрийн төлөөллийг оролцуулна.

10.2. Төрийн захиргааны байгууллага нь ашиглалтад орсон барилга байгууламжид паспорт, бүртгэлийн дугаар олгоно.

10.4. Төрийн захиргааны байгууллага Барилгын тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон норм дүрмийн заалт, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны ажилбар зөрчсөн гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлуулах санал тавьж болно.

**Арван нэг. Хариуцлага**

11.1 Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралт**

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН ХУРЛЫН ДЭГ

**Нэг. Нийтлэг Үндэслэл**

1.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах, барилгын чанар, аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлт өгч, ашиглалтад авах шийдвэр гаргах Улсын болон Техникийн комиссын үйл ажиллагааг энэхүү дэгээр зохицуулна.

**Хоёр. Хуралд бэлтгэх**

2.1. Улсын болон Техникийн комиссын хурлын бэлтгэл ажлыг комиссын нарийн бичгийн дарга, захиалагч, гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна

2.2. Улсын болон Техникийн комиссын нарийн бичгийн дарга техникийн баримт бичгийн бүрдлийг хянан үзэж шаардлага хангасан гэж үзвэл Улсын болон Техникийн комисс ажиллах мэдэгдлийг "Барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрэм"-ийн 5 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж тараана.

2.3. Улсын болон Техникийн комиссын нарийн бичгийн дарга нь Улсын болон Техникийн комиссын хурлыг зохион байгуулан гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, акт албажуулах ажлыг гүйцэтгэнэ.

**Гурав. Хурлын Үйл ажиллагаа**

3.1. Комиссын гишүүдийн дөрөвний гурав буюу 75 хувийн ирц бүрдсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

3.2. Комисс ажиллах боломжгүй тохиолдолд гишүүдийн саналыг үндэслэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дахин ажиллах тухай шийдвэрийг комиссын дарга гаргана.

3.3. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд хурал эхлэхээс 1 хоногийн өмнө комиссын даргад урьдчилан мэдэгдсэн байна. Энэ тохиолдолд гишүүн барилга байгууламжийг нөхөн шалгаж санал дүгнэлтээ комиссын нарийн бичгийн даргад маягтын дагуу хүргүүлнэ.

3.4. Комиссын гишүүн барилга байгууламжийн баримт бичигтэй танилцсаны дараа барилга байгууламжийн угсралт, тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээний ажил нь бат бэх эсэх, найдвартай ажиллагаа, зураг төсөл, барилга техникийн болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн болон галын норм, дүрэм, хийц бүтээц, эдлэхүүн, материалын чанар стандарт, техникийн нөхцөлийн шаардлага хангасан эсэхийг нарийвчлан шалгаж санал дүгнэлт өгнө.

3.5. Гишүүн нь өөрийн санал дүгнэлтээ комиссын нарийн бичгийн даргад бичгээр гаргаж өгнө.

3.6. Комиссын дарга санал, дүгнэлтүүдийг нэгтгэж уг барилга байгууламжийг ашиглалтад оруулах, эсэх асуудлаар комиссын шийдвэр гаргуулна.

**Дөрөв. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх**

4.1. Комиссын гаргасан шийдвэрийг үндэслэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах хурлын тэмдэглэлд комиссын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.

4.2. Комиссын гишүүд нь өгсөн санал дүгнэлтийнхээ биелэлтийг шалгаж, бүрэн биелсэн тохиолдолд актад гарын үсэг зурж баталгаажуулна.

**Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 2 дугаар хавсралт**

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар баригдсан, улсын болон олон улсын шинж чанартай, барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын болон Техникийн комисс дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Улсын комиссын дарга - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга болон барилга, байгууламжийн асуудал хариуцсан дэд дарга, албаны дарга, улсын ахлах байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга - Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Техникийн комиссын дарга;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох хяналтын улсын байцаагч /барилга, сантехник, хот байгуулалт, холбоо, эрчим хүч, цахилгаан, эрүүл ахуй, байгаль орчин, геодези, инженер геологи, газар/;

-Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

-Зураг төслийн байгууллагын төлөөлөл / холбогдох зохиогчид/;

-Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл;

-Ус сувгийн ашиглалтын байгууллагын төлөөлөл /ерөнхий инженер/;

-Холбоо, дохиоллын байгууллагын төлөөлөл /ерөнхий инженер/;

-Дулаан, эрчим хүчний байгууллагын төлөөлөл /ерөнхий инженер/;

-Цахилгаан эрчим хүчний байгууллагын төлөөлөл /ерөнхий инженер/;

-Аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төлөөлөл;

-Захиалагч байгууллагын төлөөлөл;

-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч байгууллагын төлөөлөл;

-Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Хөрөнгө оруулагч, захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Холбоо, дохиоллын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Цахилгаан эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Дулааны эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Ус хангамж ариутгах шугамын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Зураг төслийн байгууллага /холбогдох зохиогчид/

В. Хөдөө орон нутагт баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын болон Техникийн комисс ажиллахад түүний бүрэлдэхүүнд орон нутгийн холбогдох байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагч орж ажиллана.

2. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь улсын болон бүс нутгийн чанартай, улс орны эдийн засгийн ач холбогдолтой технологийн нарийн горим бүхий барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А.Улсын комиссын дарга -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын барилгын асуудал эрхэлсэн дэд дарга болон алба, хэлтсийн дарга, улсын ахлах байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга -Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Техникийн комиссын дарга;

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох хяналтын улсын байцаагч /барилга, хот байгуулалт, сантехник, холбоо, эрчим хүч, цахилгаан, эрүүл ахуй, байгаль орчин, геодези, инженер геологи, газар/;

- Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

- Аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төлөөлөл;

- Зураг төслийн байгууллагын төлөөлөл/ холбогдох зохиогчид/;

-Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл;

-Ус сувгийн ашиглалтын байгууллагын төлөөлөл;

- Холбоо, дохиоллын байгууллагын төлөөлөл;

-Дулаан, эрчим хүчний байгууллагын төлөөлөл;

- Цахилгаан, эрчим хүчний байгууллагын төлөөлөл;

- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Хөрөнгө оруулагч, захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Холбоо, дохиоллын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Цахилгаан, эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Дулааны эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Ус хангамж ариутгах шугамын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Зураг төслийн байгууллагын төлөөлөл/ холбогдох зохиогчид/;

-Захиалагч байгууллагын төлөөлөл.

В. Хөдөө орон нутагт баригдсан барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс ажиллахад түүний бүрэлдэхүүнд орон нутгийн холбогдох байгууллага, хяналтын улсын байцаагч орж ажиллана.

3. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь орон нутгийн шинж чанартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Улсын комиссын дарга - Аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Техникийн комиссын дарга;

-Мэргэжлийн хяналтын улсын байцаагч / барилга, хот байгуулалт, сантехник, холбоо, эрчим хүч, цахилгаан, эрүүл ахуй, байгаль орчин, геодези, инженер геологи, газар/;

- Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

- Нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл;

- Аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төлөөлөл

- Зураг төслийн байгууллагын төлөөлөл;

- Орон нутгийн Онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл;

- Ус сувгийн ашиглалтын байгууллагын төлөөлөл;

- Холбоо, дохиоллын байгууллагын төлөөлөл;

- Цахилгаан, дулааны эрчим хүчний байгууллагын төлөөлөл;

- Захиалагч байгууллагын төлөөлөл;

- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Хөрөнгө оруулагч, захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Холбоо, дохиоллын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Цахилгаан, эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Дулааны эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Ус хангамж ариутгах шугамын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Зураг тйслийн байгууллагын тйлййлйл / холбогдох зохиогчид/.

4. Бүх төрлийн барилга, байгууламжийн их болон урсгал засварын ажлыг ашиглалтад оруулах Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Техникийн комиссын дарга - Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын холбогдох улсын байцаагч

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

- Захиалагч байгууллагын төлөөлөл;

Гишүүд: - Холбоо, дохиоллын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Цахилгаан эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Дулааны эрчим хүчний гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Ус хангамж ариутгах шугамын гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

-Орон нутгийн Онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл;

-Зураг төслийн байгууллагын төлөөлөл/ холбогдох зохиогчид/;

-Архивын байгууллагын төлөөлөл.

**АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

1. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай, улсын болон олон улсын шинж чанартай, авто замын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Улсын комиссын дарга Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, авто замын хяналт хариуцсан дэд дарга, албаны дарга, авто замын улсын /ахлах/ байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга - Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Техникийн комиссын дарга;

- Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;
-Авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагч;
-Зураг төслийн байгууллагын төлөөлөл / холбогдох зохиогчид/;
- Замын цагдаагийн газрын төлөөлөл;
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч;
- Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч;
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Орон нутгийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч;

-Зураг төслийн байгууллагын төлөөлөл / холбогдох зохиогчид/;
- Замын цагдаагийн газрын төлөөлөл;
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Техник ашиглалтын түвшин тодорхойлсон байгууллагын төлөөлөл.

2. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь улсын болон бүс нутгийн чанартай, технологийн нарийн горим бүхий зам, гүүрийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Улсын комиссын дарга - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, авто замын хяналт хариуцсан дэд дарга, албаны дарга, авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга - Захиалагч байгууллагын дарга

Гишүүд: - Техникийн комиссын дарга;

- Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;
- Авто замын хяналтын улсын байцаагч;
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч;
- Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч;
- Зураг, төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл ;
- Захиалагч байгууллагын хяналтын инженер;
-Замын цагдаагийн газрын байцаагч;
-Ашиглагч байгууллагын инженер;
-Архивын байгууллагын төлөөлөл.

Б.Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч;

- Зураг, төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Замын цагдаагийн газрын байцаагч;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Техник ашиглалтын түвшин тодорхойлсон байгууллагын төлөөлөл;

В. Хөдөө орон нутагт баригдсан зам гүүрийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс ажиллахад түүний бүрэлдэхүүнд орон нутгийн холбогдох байгууллага, хяналтын улсын байцаагч орж ажиллана.

3. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь орон нутгийн шинж чанартай зам, гүүрийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. үүнд:

А. Улсын комиссын дарга -Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын дарга, авто замын хяналтын улсын байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга -Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Техникийн комиссын дарга;

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч;
- Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч;
- Инженер геологийн хяналтын улсын байцаагч;
- Зураг, төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын инженер;
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Замын цагдаагийн газрын байцаагч;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
-Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Авто замын хяналтын улсын/ ахлах/ байцаагч;

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч;
- Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч;
- Инженер геологийн хяналтын улсын байцаагч;
- Зураг, төслийн байгууллагын төлөөлөл;
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Замын цагдаагийн газрын байцаагч;

- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Техник ашиглалтын түвшин тодорхойлсон байгууллагын төлөөлөл.

4. Бүх төрлийн зам, гүүрийн байгууламжийн засвар, арчлалтын ажлыг ашиглалтад оруулах Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагч;
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч:
- Геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч;
- Инженер геологийн хяналтын улсын байцаагч;
-Зураг, төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Замын цагдаагийн газрын байцаагч;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Архивын байгууллагын мэргэжилтэн;
- Техник ашиглалтын түвшин тодорхойлсон байгууллагын төлөөлөл

## ЦАХИЛГААН, ДУЛААН, ХОЛБООНЫ ШУГАМ СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Эрчим хүчний 15 квт, түүнээс дээш хүчдэлийн цахилгаан шугам сүлжээ, дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Улсын комиссын дарга -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрчим хүчний хяналт хариуцсан дэд дарга, дэд бүтцийн хяналтын улсын албаны дарга болон эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга -Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд:-Техникийн комиссын дарга;
-Барилга техникийн хяналтын байцаагч;
-Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч;
-Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;
-Зураг төслийн байгууллагын төлөөлөл /холбогдох зохиогчид/;
-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
-Ашиглагч байгууллагын төлөөлөл;
-Архивын байгууллагын төлөөлөл;
-Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл;
- Зураг төслийн байгууллагын төлөөлөл /зураг төсөл зохиогч/;
- Ашиглагч байгууллагын төлөөлөл;
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

2. Эрчим хүчний 10 квт хүчдэлийн цахилгаан шугам сүлжээ, орон нутгийн чанартай дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. үүнд:

А. Улсын комиссын дарга - Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын дарга болон эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн аль нэг;

Нарийн бичгийн дарга - Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын холбогдох хяналтын улсын байцаагч
-Ашиглагч байгууллагын төлөөлөл;
-Зургийн төслийн байгууллагын төлөөлөл /зохиогчид/;
-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
-Захиалагч байгууллагын төлөөлөл;
-Архивын байгууллагын төлөөлөл;
-Орон нутгийн Онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Зураг төслийн байгууллагын төлөөлөл / холбогдох зохиогчид/;
-Ашиглагч байгууллагын төлөөлөл;
-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
-Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл.

3. Харилцаа холбооны шугам сүлжээ, тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын болон Техникийн комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна:

А. Улсын комиссын дарга -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд бүтцийн хяналтын улсын албаны дарга болон мэдээлэл, холбооны хяналтын улсын ахлах байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга -Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд:-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох хяналтын улсын байцаагч;
-Харилцаа, холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;
-Захиалагч байгууллагын төлөөлөл;
-Зураг төслийн байгууллагын төлөөлөл / холбогдох зохиогчид/;
-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
-Ашиглагч байгууллагын төлөөлөл;
-Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх байгууллагын төлөөлөл;
-Архивын байгууллагын төлөөлөл.

Б. Техникийн комиссын дарга - Захиалагч байгууллагын дарга

Нарийн бичгийн дарга - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: - Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл;
-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
-Ашиглалтын байгууллагын төлөөлөл;
-Зураг төслийн байгууллагын төлөөлөл /зураг төсөл зохиогч/;
-Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

4. Хөдөө аж ахуйн инженерийн байгууламж шугам сүлжээ, тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Улсын комиссын дарга-Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын дарга, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн аль нэг

Нарийн бичгийн дарга-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд: -Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Ашиглалтын байгууллагын төлөөлөл;
- Зураг төслийн байгууллагын төлөөлөл /холбогдох зохиогчид/;
-Орон нутгийн хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөл;
- Архивын байгууллагын төлөөлөл.

**Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3 дугаар хавсралт**

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН АКТ

**2009 оны ... дугаар сарын ..-ны өдөр** **Дугаар ...** **Улаанбаатар хот**

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал

____________________________________________

____________________________________________

____________________

1.2. Хөрөнгө оруулагч, захиалагч аж ахуйн нэгж, байгууллага

____________________________________________

____________________________________________

____________________

1.3. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага

____________________________________________

____________________________________________

____________________

1.4. Зураг төсөв боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага

1.5. ____________________________________________

____________________

шийдвэрээр зохион байгуулсан ... хүний бүрэлдэхүүнтэй Улсын комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын 20.. оны .. -р сарын ..-ны өдрийн тоот мэдэгдлийн дагуу 20.. оны .. -р сарын ..-ны өдрөөс .. -ны өдөрт багтаан шинээр барьсан өргөтгөл, шинэчлэл, их болон урсгал засварын (доогуур нь зур) ажлын гүйцэтгэл, ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.

1.6. Энэхүү барилга байгууламжийг ........ дугаартай зураг төслөөр ...... оны .. –р сараас барьж эхэлсэн бөгөөд ... оны .. -р сарын .. -ны өдөр барьж дууссан байна.

### ХОЁР.

2.1. Энэ ____________________________________________

____________________________________________

____________________

барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалгаад Улсын комиссоос шийдвэрлэсэн нь:

____________________________________________

____________________

Тэмдэг ____________________________________________

____________________

______________________________________________________________________

____________________

______________________________________________________________________

____________________

2.2. Энэ барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж

______________________________________________________________________

____________________

зориулалтаар ашиглахад ____________________ гэж үзээд хөрөнгө оруулагч, захиалагч (ашиглагч) болох ____________________ ____________мэдэлд 20.. оны .. -р сарын .. -ны өдрөөс ашиглалтад үйлдвэрлэл, үйлчилгээ оршин суух (аль нь болохыг доогуур нь зурах) оруулахыг зөвшөөрөв.

2.3. Улсын комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын акт, холбогдох баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад .. хоногийн дотор багтаан шилжүүлэх

Захиалагч (ашиглагч) байгууллагад:

а) улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уг барилга байгууламжийн холбогдох баримтуудыг ... хоногийн дотор багтаан бүртгүүлэх;

б) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх;

в) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгыг хэвийн ашиглаж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх;

г) Барилгын тухай хуулийн 12.4-т заасан барилгын чанарын баталгаат хугацаа дуусгавар болсон тохиолдолд ашиглагч, гүйцэтгэгч, өмчлөгч, зураг төсвийн байгууллагууд хамтран үзлэг хийж тэмдэглэл хөтлөн баталгаажуулж, шаардагдах засварын ажлуудыг гүйцэтгүүлэн акт үйлдсэнээр уг барилгын баталгаат хугацааг дуусгавар болгуулах.

2.4. Улсын комиссын акт ... хуудас, хурлын тэмдэглэл ... хуудас, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.

/Тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ/

**УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:**

Комиссын дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар:

Энэхүү хуудсанд Улсын комисст ажилласан гишүүдийн нэр багтахгүй дараагийн хуудсанд бичигдсэн тохиолдолд хуудасны дээд талд тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ТЕХНИКИЙН КОМИССЫН АКТ

20..оны..-р ..сарын..-ны өдөр Дугаар Улаанбаатар хот

НЭГ.

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал______________________________

1.2. Хөрөнгө оруулагч, захиалагч аж ахуйн нэгж, байгууллага______________________________

1.3. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага______________________________

1.4. Зураг төсөв боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага______________________________

1.5. ______________________________

шийдвэрээр зохион байгуулсан .... хүний бүрэлдэхүүнтэй Улсын комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын 20.. оны ..-р сарын ..ны өдрийн ... тоот мэдэгдлийн дагуу 20.. оны ..-р сарын ..-ны өдрөөс ... өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл шинэчлэл, их засварын ажлын гүйцэтгэл, ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.

1.6. Энэхүү барилга байгууламжийг ...... дугаартай зураг төслөөр .... оны .. сараас барьж эхэлсэн бөгөөд .... оны ..-р сарын ..-ны өдөр барьж дууссан байна

ХОЁР.

2.1. Энэхүү______________________________

барилга байгууламж, холбогдох акт баримтуудыг шалгаад ашиглалтад оруулах тухай техникийн комиссоос:
______________________________

тэмдэг

______________________________шийдвэрлэв.

2.2. Техникийн комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг ... хувь үйлдэв.

2.3. Энэ барилга байгууламжийн бүх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

а) барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл .... хуудас, ил далд актууд .... хуудас, гүйцэтгэлийн схем, зургууд ... хуудас;

б) техникийн зураг, техникийн баримт бичгүүд ... хуудас;

в) техникийн бусад баримт материал ........ хуудас;

г) барилга байгууламжид ажилласан техникийн комиссын акт ....... хуудас;

д) Техникийн комиссын гишүүдийн санал, дүгнэлт, эцсийн шийдвэрийг тэмдэглэсэн хурлын тэмдэглэл .... хуудас

е) зурагт орсон өөрчлөлтийн материал ....... хуудас

/Тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ/

**ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:**

Комиссын дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар:

Энэхүү хуудсанд Техникийн комисст ажилласан гишүүдийн нэр багтахгүй дараагийн хуудсанд бичигдсэн тохиолдолд хуудасны дээд талд тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

**Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 5 дугаар хавсралт**

МЭДЭГДЭЛ

Дугаар ...

Комисст оролцох байгууллагын нэр ..............................................................

Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 2 дугаар хавсралтаар томилогдсон бүрэлдэхүүнтэй Улсын /Техникийн/ комисс нь________________________________________________
........................................................................................................зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар .... оны .. -р сарын ..-ны өдрийн .... цагт ажиллах болсон тул комиссын гишүүн .......................................................... таныг хүрэлцэн ирэхийг мэдэгдье.

Байршил: ................................ дүүргийн ......-р хороо ..................................................

Комиссын нарийн бичгийн дарга ............................ /............................../

...........оны ......... –р сарын .........-ны өдөр

Таслах

шугам

ТАСАЛБАР

Дугаар ...

Комисст оролцох байгууллагын нэр ..........................................................................

Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 2 дугаар хавсралтаар томилогдсон бүрэлдэхүүнтэй Улсын /Техникийн/ комисс нь

-ны

..............................................................................................................................

зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар .... оны ..-р сарын ..-ны өдрийн ..... цагт ажиллах болсон тул комиссын гишүүн ........................................ таныг хүрэлцэн ирэхийг мэдэгдье.

Хүлээн авсан

....................................................

.....оны ... -р сарын ...-ны өдөр

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 6 дугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ ЖИШИГ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

| № | Бүрдүүлж хөтөлсөн байх баримт бичиг | Баримт бичгийн он,сар, өдөр | Хувь | Хавсралтын дугаар |
|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| | А) барилга байгууламжийг ашиглалтад оруулахын өмнө бүрдүүлсэн байх бичиг баримтууд | | | |
| 1 | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх бүртгэлийн гэрчилгээ | | | |
| 2 | Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл | | | |
| 3 | Барилга хариуцсан даамлыг томилсон тушаал | | | |
| 4 | Барилга барих газар олгосон тухай аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, мэдэгдэл | | | |
| 5 | Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд (ус суваг, дулаан, цахилгаан, холбоо дохиолол) | | | |
| 6 | Улаан шугам тавьсан акт түүнийг тавихад гаргасан зай хэмжээний зураг | | | |
| 7 | Барилга барих газрын хөрсний шинжилгээний дүгнэлт | | | |
| 8 | Ажлын иж бүрэн зураг төсөл магадлал хийгдсэн | | | |
| 9 | Захиалагч, зохиогч, ерөнхий гүйцэтгэгч байгууллагын хооронд хийсэн гэрээнүүд | | | |
| 10 | Захиалагч байгууллага зураг төслийг гал, ариун цэвэр, архитектур, хот байгуулалтын байгууллагуудтай зөвшөөрөлцсөн тодорхойлолт | | | |
| 11 | Зураг төслийн байгууллагаар гаргуулсан зохиогчийн нэгдсэн дүгнэлт | | | |
| 12 | Захиалагч, зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд барилга байгууламжийн угсралт, тоног төхөөрөмжийн Техникийн чанарыг хамтран шалгасан гүйцэтгэлийн акт /УББ 12-01-01/ | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Ил далд техникийн акт, техникийн баримт бичгүүд | | | |
| | Б) барилга угсралтын ажлын явцад бүрдүүлсэн баримт бичиг | | | |
| 14 | Улаан шугамыг шалгаж тэг, тэнхлэг татсан акт | | | М-1 |
| 15 | Суурийн нүх ухсан акт | | | М-2 |
| 16 | Суурь хийсэн акт | | | М-3 |
| 17 | Ханын өргийн акт | | | М-4 |
| 18 | Хана сууринд төмөр бетон бүс хийсэн акт | | | М-5 |
| 19 | Төмөр бетон зүрхэвч цутгасан акт | | | М-6 |
| 20 | Хаалга цонхны ялуүг суулгасан акт | | | М-7 |
| 21 | Хананд салхивч ба утааны суваг хийсэн акт | | | М-8 |
| 22 | Газар хөдлөлтийн арга хэмжээний зориулалттай тусгай хийцийг гүйцэтгэсэн акт | | | |
| 23 | Модон хучилт хийсэн акт | | | М-9 |
| 24 | Төмөр дээвэр хийсэн акт (дулаалга) /а/, хавтгай дээвэр хийсэн акт /б/. | | | М-10 |
| 25 | Угсармал төмөр бетон хучилт хийсэн акт | | | М-11 |
| 26 | Угсармал төмөр бетон дам нуруу, багана угсарсан акт | | | М-12 |
| 27 | Цутгамал төмөр бетон бүтээцийн арматурласан акт | | | М-13 |
| 28 | Цутгамал төмөр бетон бүтээц хийсэн акт | | | М-14 |
| 29 | Тагт,карнизын төмөр бетон хавтанг бэхэлсэн акт | | | М-15 |
| 30 | Төмөр бүтээцийг угсарч гагнасан акт | | | М-16 |
| 31 | Дотор халаалтын системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М–17 |
| 32 | Дотор бохир усны системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М-18 |
| 33 | Гадна бохир усны системийг угсарсан, шалгасан акт | | | М-19 |
| 34 | Дотор халуун хүйтэн усан хангамж, гал эсэргүүцэгч системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М-20 |
| 35 | Гадна дулаан, цэвэр усан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М-21 |
| 36 | Халаалтын тогоо, түүний тоног төхөөрөмжүүдийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М-22 |
| 37 | Дулааны зангилгаа, ус халаагчийг угсарсан акт | | | М-23 |
| 38 | Барилгын салхивчийн системийг угсарч, сорилт хийсэн акт | | | М-24 |
| 39 | Барилгын гадна цахилгааны шугамыг хийсэн акт | | | М-25 |
| 40 | Дотор цахилгааны угсралтын ажил, туршилт хийж шалгасан акт | | | М-26 |
| 41 | Тоног төхөөрөмжийн суурь хийсэн ба тоног төхөөрөмжийг байрлуулж угсарсан акт | | | М-27 |
| 42 | Тоног төхөөрөмжид туршилт хийсэн акт (а, б) | | | М-28 |
| 43 | Тоног төхөөрөмжид цахилгаан холболт газардуулга хийсэн акт (нэг бүрээр) | | | М-29 |
| 44 | Тоног төхөөрөмжүүдэд контур газардуулга хийсэн, шалгасан акт | | | М-30 |
| 45 | Барилгад аянга зайлуулагч хийсэн, туршсан акт | | | М-31 |
| 46 | Шат угсарсан акт | | | М-32 |
| 47 | Уур, ус тусгаарлалтын ажил хийсэн, шалгасан акт | | | М-33 |
| 48 | Хучилт, дээврийн дулаалгын ажлыг хийсэн акт | | | М-34 |
| 49 | Гадна дотор будаг, заслын ажил хийсэн акт | | | М-35 |
| 50 | Барилга угсралтын явцад өөрчилсөн бусад шийдвэрлэсэн асуудлуудад холбогдох баримт бичгүүд хуулбар буюу эх материал | | | |
| 51 | Хүн ба тээш зөөврийн лифтийн тоног төхөөрөмжийг угсарсан, шалгаж туршсан акт | | | М-36 |
| 52 | Лифтийн цахилгаан холболтыг хийсэн, шалгасан акт | | | М-37 |
| 53 | Лифтийг гүйцэтгэгч байгууллагаас хүлээлгэж өгсөн акт | | | М-38 |
| 54 | Гадаад оронтой хийсэн гэрээ, хэлэлцээр, зээл тусламжаар хийгдэх зүйлүүд | | | |
| | а)гэрээ хэлэлцээрт (контрактад) дурдсанаар бүрэн бүтэн чанар үзэмжтэй хийгдсэн эсэх тодорхойлолт | | | |
| | б)тоног төхөөрөмж, эд хогшил, машин механизм нь зураг төсөл, контрактад заагдсанаар бүрэн тоо ширхгээр зөв байрлагдаж угсрагдсан болон угсрагдахгүй бүрэн бүтэн тоо ширхгээр бүгд ирсэн эсэх тухай жагсаалт | | | |
| | в)гэрээ хэлэлцээрт зураг төсөвт заагдсанаас хасагдаж хийгдэхгүй болсон мөн хийгээгүй зүйлийн жагсаалт | | | |
| | г)цаашдын ашиглалтад зориулагдаж ирсэн сэлбэг түлхүүр, багаж хэрэгслийн жагсаалт | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 55 | Удирдах ба зураг төсвийн болон хяналт шалгалтын байгууллагуудаас шалгаад өгсөн акт, шаардлага түүний биелэлтийн хувиуд | | | |
| 56 | Зураг төслөөс өөрчилж хийсэн зүйлийн жагсаалт, түүнийг хаанаас хэн өөрчилсөн тодорхойлолтууд | | | |
| 57 | Инженерийн шугам сүлжээ болон даацын үндсэн бүтээцийн гүйцэтгэлийн зураг | | | |
| 58 | Барилгын ажлын өдөр тутмын тэмдэглэл Тайлбар:<br>1. Энэ жагсаалтыг барилга байгууламжийг хүлээлгэн өгөхдөө 2 хувь бэлтгэсэн байна.<br>2. Барилгын өдөр тутмын тэмдэглэлийг архивт хадгалах хувьд хавсаргана. | | | |
| 59 | Гадна зам талбай, тохижилт хийсэн акт | | | М-39 |
| | В) барилга байгууламжийг ашиглалтад оруулахын өмнө бүрдүүлсэн байх бичиг баримтууд | | | |
| 60 | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх зөвшөөрөл | | | |
| 61 | Авто замын барилга хариуцсан замын инженер, талбайн даамлыг томилсон тушаал | | | |
| 62 | Авто зам барих газар олгосон тухай аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, мэдэгдэл | | | |
| 63 | Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд (ус суваг, дулаан, цахилгаан, холбоо дохиолол) | | | |
| 64 | Улаан шугам тавьсан акт түүнийг тавихад гаргасан зай хэмжээний зураг | | | |
| 65 | Авто зам барих газрын геологи хайгуулын судалгааны дүгнэлт | | | |
| 66 | Ажлын иж бүрэн зураг төсөв, техникийн шаардлага | | | |
| 67 | Захиалагч, ерөнхий гүйцэтгэгч байгууллагын хооронд хийсэн гэрээнүүд | | | |
| 68 | Зураг төслөөс өөрчлөлт орсон зүйлийн жагсаалт, түүнийг хаанаас хэн өөрчилсөн тодорхойлолтууд | | | |
| 69 | Захиалагч байгууллага зураг төслийг архитектур, хот байгуулалтын байгууллагуудаар хяналт хийлгүүлж зөвшөөрөл авсан тухай тодорхойлолт | | | |
| | Г) авто зам, гүүрийн барилга байгууламжийг гүйцэтгэх явцад бүрдүүлэх баримт бичиг | | | |
| 70 | Зам, гүүр, онгоц хөөрч буух зурвасын тэнхлэг тавьсан акт, түүнийг тавихад гаргасан зай хэмжээний зураглал | | | |
| 71 | Удирдах ба зураг төсвийн болон хяналтын байгууллагаас өгсөн шаардлага, акт, дүгнэлт тэдгээрийн биелэлт | | | |
| 72 | Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд нөөц ордын материалын шинжилгээ, замын барилгын явцад лабораторийн хяналт хийсэн шинжилгээний баталгаажуулсан баримт, материал, асфальтобетон хольц, буталсан чулуун суурь, цементбетоны орц тогтоосон баримт /бүх шинжилгээг хавсарсан/ | | | |
| 73 | Гүйцэтгэлийн зураг, үндсэн болон туслах реперийг хүлээн авах | | | |
| 74 | Авто замын хувьд Бамп интеграторaар хэмжсэн тэгш байдлын үзүүлэлт, график | | | |
| 75 | Карьер, орд газруудыг буцаан дарсан акт | | | |
| 76 | Зам, замын байгууламж, онгоц хөөрч буух зурвасын техник ашиглалтын түвшин тогтоох үзүүлэлтүүдийг шалгах /замын тэгш байдал, хучилтын бат бөх, гадаргуугийн гулсалтын эсэргүүцэл, гадаргуугийн дугуй мөрний хотойлт, гадаргуугийн барзгаржилт, далан суурийн даац, хурдны хангалт , хучилтын зузаан, нягт, геометр хэмжээс г.м/<br>Хайрган хучилттай авто замын далан суурийн даац, нягтралын хувь, геометр хэмжээс г.м/<br>Гүүрийн бүтээцүүдийг зөв байрлуулсан эсэх, гаднаас харагдах согог, гэмтэл, элементүүд тулах гадаргуутай болон өөр хоорондоо нягт нийлсэн байдал, угсралтын холбоос залгаасны холбох чанар, зураг төслийн шаардлагын биелэлт г.м/ | | | |
| 77 | Авто зам, замын байгууламж, гүүр, онгоц хөөрч буух зурвасын далд ажлын техникийн акт | | | |
| | Д) эрчим хүчний барилга байгууламж шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг угсрахад бүрдүүлэх бичиг баримт | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 78 | Зураг төслөөс өөрчлөгдөн хийгдсэн ажлын жагсаалт | | | М-40 |
| 79 | Техникийн баримт бичгүүд | | | М-41 |
| 80 | Дутуу ажлын жагсаалт | | | М-42 |
| 81 | Кабелийг хүйтний улиралд сунгахын өмнө халаасан протокол | | | М-43 |
| 82 | Кабель шугамыг шулуутгасан өндөр хүчдэлээр шалгасан протокол | | | М-44 |
| 83 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын паспорт | | | М-45<br>М-46 |
| 84 | Тулгуурын далд ажлын акт | | | М-47 |
| 85 | Трансформаторын дэд станцын паспорт | | | М-48 |
| 86 | Цэнэг шавхагч шалгасан протокол | | | М-49<br>М-50 |
| 87 | Хуурай салгуур шалгасан протокол | | | М-51 |
| 88 | Газардуулах байгууламжийн паспорт | | | М-52 |
| 89 | Газардуулгын хүрээний эсэргүүцэл шалгасан протокол | | | М-53 |
| 90 | 1000 квт-аас бага чадлын хүчний трансформаторт туршилт хийсэн протокол | | | М-54 |
| 91 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн үзүүлэлтүүд:<br>1. Төмөр бетон тулгуур<br>2. Суурь<br>3. Тусгаарлагч<br>4. Утасны бэхэлгээний тоноглолууд<br>5. Хэт хүчдэлийн хамгаалалт<br>6. Агаарын шугамын газардуулга | | | М-55 |
| 92 | Гарц ба огтлол<br>Гарц ба огтлолын үзлэгийн акт<br>Дэд станцын холбооны төхөөрөмжүүд<br>Бусад тэмдэглэл | | | М-56 |
| 93 | Төмөр тулгуурын суурь угсрах ажлын журнал | | | М-57 |
| 94 | Төмөр бетон тулгуур угсралтын журнал | | | М-57 |
| 95 | Төмөр тулгуурын угсралтын ажлын протокол | | | М-58 |
| 96 | Анкерийн алгасалтын утас угсралтын ажлын журнал | | | М-59 |
| 97 | Тулгуурын газардуулгын хүрээний эсэргүүцэл хэмжсэн протокол | | | М-60 |
| 98 | Хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн жагсаалт | | | М-61 |
| 99 | Тосон хийц таслуур шалгасан протокол | | | М-62 |
| 100 | Цахилгаан тоног төхөөрөмжийн тосонд туршилт хийсэн протокол | | | М-63 |
| 101 | Хуваарилах байгууламжид туршилт хийсэн протокол | | | М-64 |
| 102 | Цахилгаан тоног төхөөрөмжийн тосонд хатаалт хийсэн протокол | | | М-65 |
| 103 | Хуваарилах байгууламжийн далд ажлын акт | | | М-66 |
| 104 | Шитний холболт шалгасан тухай протокол | | | М-67 |
| 105 | Дотоод цахилгаан холболтын далд ажлын акт | | | М-68 |
| 106 | Гэрэлтүүлгийн ажил хийсэн тухай акт | | | М-69 |
| 107 | Дэд станцын төмөр бүтээц гагнасан тухай акт | | | М-70 |
| 108 | Хүчний трансформаторт хийсэн туршилт, сорилтын ажлын протокол | | | М-71 |
| 109 | Хоёрдогч хэлхээний угсралтын ажлыг шалгасан протокол | | | М-72 |
| 110 | Дулааны шугамын улаан шугам татсан акт | | | М-73 |
| 111 | Дулааны шугам хоолойн далд техникийн акт | | | М-74 |
| 112 | Камерын далд техникийн акт | | | М-75 |
| 113 | Гадна дулаан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | | | М-76 |
| 114 | Дулааны шугам хоолойг угсарч, хүлээн авсан акт | | | М-77 |
| 115 | Шугам хоолойн угаалга хийсэн акт | | | М-78 |
| 116 | Шугам хоолойн бат бэх, нягтын байдлыг туршиж шалгасан тухай акт | | | М-79 |
| 117 | Компенсаторын таталтыг хийсэн тухай акт | | | М-80 |
| 118 | Даралтат савыг угсарсан болон түүний нягтыг шалгасан акт | | | М-81 |
| 119 | Зуух, даралтат сав шугам хоолойн угсралтын үед хийгдэх гагнуурын ажилд бүрдүүлэх материалууд | | | М-82 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Е) харилцаа холбооны барилга байгууламж шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг угсрахад бүрдүүлэх бичиг баримт | | | | |
| 120 | Холбооны кабель шугамын сувагчлалын угсралтын далд техникийн акт | | | М-83 |
| 121 | Кабелын шөрмөсийн залгааг модуль коннектороор хийсэн байдлыг шалгасан акт | | | М-84 |
| 122 | Холбооны кабель шугамын байгууламжийг сүлжээнд холбох техникийн акт | | | М-85 |
| 123 | Радионы дотор угсралт хийсэн, шалгасан акт | | | М-86 |
| 124 | Телефоны дотор угсралт хийсэн, шалгасан акт | | | М-87 |
| 125 | Радионы гадна холболтын угсралт хийсэн, шалгасан акт | | | М-88 |
| 126 | Телефоны гадна холболтын угсралт хийсэн, шалгасан акт | | | М-89 |
| 127 | Шилэн кабелын угсралтыг ашиглалтад хүлээн авах акт | | | М-90 |
| 128 | Барилга байгууламжийн галын болон хамгаалалтын дохиолол, теле-хяналтын системийн угсралтын ажил хүлээлцсэн акт | | | М-91 |
| 129 | Барилга байгууламжийн компьютерийн сүлжээ, домофон системийн /бусад дохиолол/ угсралтын ажил хүлээлцсэн акт | | | М-92 |
| 130 | Барилга байгууламжийн КаТв-ын сүлжээний холболтыг шалгасан акт | | | М-93 |
| 131 | Шуудангийн хайрцагжуулалтыг ашиглалтад хүлээн авсан акт | | | М-94 |
| 132 | Мэдээлэл, харилцаа холбооны техник тоног төхөөрөмжид газардуулга хийж туршсан тухай акт | | | М-95 |
| 133 | Мэдээлэл, харилцаа холбооны техник тоног төхөөрөмжид аянга зайлуулагч хийж туршсан акт | | | М-96 |
| Ж) бусад баримт бичиг | | | | |
| 128 | Материалын тохирлын гэрчилгээ | | | |
| 129 | Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ | | | |

Тайлбар: Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хүчдэлийн түвшнээс хамааруулан тухайн шугам дэд станцын тоноглолын үйл ажиллагаанд зайлшгүй холбоотой хэмжилт туршилтыг хийж акт протоколыг бүрдүүлнэ.

**Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

## БАРИЛГА АШИГЛАЛТЫН ДҮРЭМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Барилгын норм, дүрмийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан бүх төрлийн барилга байгууламжийн ашиглалт /цаашид "барилга ашиглалт" гэх/-тай холбоотой харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Барилга ашиглалтын хэвийн нөхцөл, найдвартай ажиллагааг хангах, ашиглалтын хугацаанаас өмнө элэгдэж эвдрэхээс хамгаалах, зориулалтаар нь зөв зохистой ашиглах ерөнхий шаардлагыг тогтоох, шаардлагатай засвар, шинэчлэлийг цаг тухайд нь хийх, түүнд хяналт тавихад энэ дүрмийн зорилго оршино.

1.3. Барилга байгууламжийн зориулалт, техник, технологийн онцлогоос шалтгаалан тухайн барилга байгууламжийн ашиглалтын үйл ажиллагааг зохицуулсан нэмэлт шаардлагыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож болно.

### Хоёр. Барилга байгууламж өмчлөгчийн үүрэг

2.1. Барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч /цаашид "өмчлөгч" гэх/ нь барилга байгууламжийн техникийн баримт бичгийг бүрдүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэх, барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан буюу ашиглаж эхэлсэн үеэс эхлэн хувийн хэрэг хөтөлж, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах бөгөөд тухайн барилгыг цаашид ашиглах боломжгүй тухай мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэн улсын бүртгэлээс хасуулна.

2.2. Өмчлөгч нь барилга байгууламжийг ашиглахдаа Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасныг баримтлан, дараахь шаардлагыг хангаж ажиллана:

2.2.1. хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх;

2.2.2. барилгын орчны тохижилтын засвар арчлалтыг тогтмол хийх, авто болон явган хүний зам, талбайн хөдөлгөөнийг хаах зэргээр бусдад саад учруулахгүй байх;

2.2.3. барилгын дээвэр, адрын хучилт болон бусад бүтээц дээр цас мөс, хог шороо, тоосонцор болон бусад зүйлс хуримтлагдан даац хэтэрч осол гарахаас сэргийлэх;

2.2.4. барилгын даацын бүтээц, хийц болон дотор, гадна инженерийн шугам сүлжээнд байнгын хяналт тавих;

2.2.5. галын аюулгүй байдал болон ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийн шаардлагыг биелүүлэх;

2.2.6. барилгад зурагт болон гэрлэн чимэглэл зэрэг нэмэлт тоног төхөөрөмж байрлуулах ажлын зураг төсөл, түүний угсралт, бэхэлгээг эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж, барилгын хийц бүтээцэд эвдрэл, гэмтэл, орчин тойронд аюул осол гарахаас урьдчилан сэргийлэх;

2.2.7. барилгын хийц, бүтээцэд ан цав, цууралт үүссэн зэрэг ноцтой эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээ авах.

2.3. Барилга байгууламжийн ашиглалтын явцад техникийн үзлэг, шалгалт явуулах, сэргээн засварлалт, засвар, үйлчилгээ хийх болон тэдгээрийн үндсэн бүтээцийн шийдлээс хамааруулан ашиглалтын хугацааг тодорхойлохдоо "Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм" БНбД 13-04-03-ыг өмчлөгч бүх байгууллага, аж ахуйн нэгж заавал мөрдөж, дараахь арга хэмжээг авна:

2.3.1. төлөвлөгөөт үзлэгийг ерөнхий болон хэсэгчилсэн байдлаар хийж, ерөнхий үзлэгээр барилга байгууламжийн техникийн байдлыг бүхэлд нь орчны тохижилтын хамт, хэсэгчилсэн үзлэгээр барилгын эдлэхүүн, хийц хэсэглэл, орчны тохижилтын хэсэг тус бүрийг хянах. Ерөнхий үзлэгийг хавар, намрын улиралд тус бүр 1 удаа, хэсэгчилсэн үзлэгийг ашиглах хугацааны явцад үүссэн эвдрэл, гэмтлийг тогтооход гүйцэтгэх;

2.3.2. төлөвлөгөөт бус үзлэгийг гал түймэр, аадар бороо, аянга, хүчтэй салхи, үгалз, цасны хунгаралт, нуралт, усны үер, газар чичирхийлэл зэрэг байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, үйлдвэрлэлийн ослын ул мөр арилаагүй үед барилга байгууламжид гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэн арилгах зорилгоор хийх;

2.3.3. барилга байгууламжийн үндсэн бүтээц, төрлөөс хамааруулан ашиглалтын явцад гүйцэтгэх ээлжит урсгал, их засварын ажлын хугацааг БНбД 13-04-03-ын хүснэгт 1-д заасны дагуу тогтоон мөрдөж ажиллах;

2.3.4. барилга байгууламжийн үндсэн хэсгийн их засварын ажлын хугацааг барилга байгууламжийн бүтээц, эдлэлийн төрлөөс хамааруулан БНбД 13-04-03-ын хүснэгт 2-т заасны дагуу тогтоон, хэрэгжүүлж ажиллах.

2.4. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын зориулалт, төлөвлөлт, хийц, бүтээцийг өөрчлөх тохиолдолд Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийг дагаж мөрдөнө.

2.5. Барилга байгууламжид өргөтгөл, шинэчлэл, урсгал, их засвар хийх тохиолдолд дараахь үүргийг хэрэгжүүлж ажиллана:

2.5.1. тухайн барилгын өргөтгөл, шинэчлэл, урсгал болон их засварын ажлын зураг төслийг Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийг баримтлан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

2.5.2. тухайн барилгын өргөтгөл, шинэчлэл, урсгал болон их засварын ажлыг Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, хүлээн авах;

2.5.3. тухайн барилгын өргөтгөл, шинэчлэл, урсгал болон их засварын ажлын гүйцэтгэлд Барилга захиалагчийн дүрмийн дагуу хөрөнгө оруулагч, захиалагчаар хяналт тавиулах;

2.5.4. барилгын өргөтгөл, шинэчлэл, их засварын ажлын зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

2.5.5. барилга байгууламжийн баталгаат хугацаа (3 жил) дуусгавар болсон тохиолдолд Барилгын тухай хуулийн 12.5-д заасны дагуу хамтарсан үзлэг хийж, холбогдох арга хэмжээг авах. Баталгаат хугацаа дуусгавар болж, хуулийн дагуу хамтарсан үзлэг хийгээгүй нөхцөлд барилга байгууламжид үүссэн хохирлыг зөвхөн өмчлөгч хариуцна.

**Гурав. Барилга байгууламж өмчлөгчийн эрх**

3.1. Өмчлөгч нь ээлжит үзлэгийг барилга байгууламжийн ангилал, зориулалт, бүтээцийн бат бэх байдал, хэвийн найдвартай ажиллагаанаас хамааруулан 2-5 жил тутам эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж дүгнэлт гаргуулах эрхтэй.

3.2. Барилга байгууламжийн өмчлөгч үзлэгээр илэрсэн эвдрэл, гэмтлийг тухай бүр цаг алдахгүй арилгуулах арга хэмжээ авна.

3.3. Өмчлөгч нь барилга байгууламжид хийх техникийн үйлчилгээг ашиглалтын хугацааны туршид тогтмол гүйцэтгүүлж байна.

**Дөрөв. Барилга байгууламж өмчлөгчид хориглох зүйл**

4.1. Өмчлөгч нь барилга байгууламжийг ашиглахдаа дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1. барилга байгууламжид эвдрэл гэмтэл учруулах, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр даацын үндсэн хийц бүтээц, зориулалтыг өөрчлөх;

4.1.2. тухайн барилга байгууламжид байгаль орчин болон хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа явуулах;

4.1.3. зураг төсөлд тусгаснаас хэтрүүлэн ус, дулаан, эрчим хүчний алдагдал гаргах, инженерийн шугам сүлжээнд хэт ачаалал өгөх;

4.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр болон харилцан тохиролцолгүйгээр эзэмшлийн бус бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус хангамжийг таслах;

4.1.5. тухайн барилгын орчны тохижилтыг батлагдсан зураг төслөөс өөрчлөх.

**Тав. Барилга ашиглалтын дүрэм зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

5.1. Энэ дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 18 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэх/ 130 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1.1. Сонгох, сонгогдох болон бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд "**саад хийсэн**" гэдэгт Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуульд тусгайлан заасан хориг, хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэний дээрхи эрхийг аливаа хэлбэрээр эдлүүлэхгүй байгаа санаатай үйлдэл / эс үйлдэхүй/-г ойлгоно.

1.2. Сонгуулийн хорооны ажиллагаанд "**саад хийсэн**" гэж хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллагыг үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлнэ.

1.3. "**Хуурч мэхлэх**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т заасначар буюу "үгээр болон үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэх"-ийг ойлгоно.

1.4. "**Санал худалдаж авах**" гэдэгт иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсхүл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эсхүл эд хөрөнгийн давуу эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн зэргийг хамааруулна.

2. Хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан "**бусад албан тушаалтан**" гэдэгт нэр дэвшигчдийн болон сонгогчдын нэрсийн жагсаалт, нэр дэвшигчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэрэг сонгуулийн баримт бичгийг олгох үндэслэл болж буй анхан шатны бүртгэл, баримт бичиг, иргэний үнэмлэхийг энэ зүйл, заалтад дурдсан зорилгоор хуурамчаар үйлдсэн албан тушаалтныг хамааруулж ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "**саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн**" үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар тогтоосон саналаа чөлөөтэй илэрхийлэх журмыг зөрчсөн, сонгуулийн хэсэгт саналаа тэмдэглэх тасалгаа, хаалтгүй байх, саналаа тэмдэглэхэд нь илдэв саад үүсгэх, тухайн сонгогчоос өөр гадны хүнийг дэргэд нь байлгах, саналаа хэрхэн өгч байгаа байдалд нь шууд хяналт тавих, саналын хайрцгийг битүүмжлэхгүй байх, саналын хуудсанд тэмдэглэл хийж чадахгүй сонгогчийн саналыг итгэмжлэгдээгүй хүнээр тэмдэглүүлэх, тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, тэмдэггүй саналын хуудсаар санал өгүүлэх зэрэг хэлбэрээр илэрч болно.

3. Хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д заасан "**Жагсаал, цуглаан зохион байгуулахад саад учруулсан**" гэдэгт түүнийг хуулийн хүрээнд зохион байгуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, зохион байгуулах хороо, санаачлагчдын үйл ажиллагаанд эсхүл хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа жагсаал, цуглааны ажиллагаанд аливаа хэлбэрээр хориг, хязгаарлалт тогтоохыг ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "**ялгаварлан гадуурхсан**" гэж жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэний төрөлхийн болон жам ёсны, түүнчлэн бусад эрхийг нь хориглох буюу хязгаарлахыг хэлнэ.

4. Хуулийн 133 дугаар зүйлийн 133.1-д заасан "**гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа**" гэдэгт Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлээр хориглосон зүйл хамаарна.

5. Хуулийн 135 дугаар зүйлийн 135.1-д заасан "**иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдал**" гэдгийг иргэний захидал, яриа, шуудангийн цахилгаан мэдээ, факс, дуут болон үсгэн, дүрст цахим мэдээ, баримт бичиг, биет зүйлийг илгээгч болон түүнийг хүлээн авагч хүний зөвшөөрөлгүйгээр бусад хүмүүст агуулгыг нь задлахыг хориглоно гэж ойлгоно.

Харин гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, баривчлах зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтан, прокурорын зөвшөөрөлтэйгээр иргэний захидал, харилцаатай танилцсаныг гэмт хэрэг гэж үзэхгүй.

Мөн зүйлийн 135.2-т заасан "**албан тушаалын байдлаа урвуулж**" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулна.

Энэ хэсэгт заасан "**эрх мэдлээ хэтрүүлж**" гэж хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхийг хэлнэ.

Мөн хэсэгт заасан "**тусгай техник, хэрэгсэл ашиглаж**" гэдэгт нууцаар сонсох, харах, хувилж авах зэрэг зориулалт бүхий төхөөрөмжийг хууль бусаар хэрэглэснийг ойлгоно.

6. Хуулийн 136 дугаар зүйлийн 136.2-т заасан "**олон нийтэд тараасан**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн

51 дүгээр тогтоолын 1.4-т заасанаар ойлгож хэрэглэнэ.

7. Хуулийн 137 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдснаар тайлбарласугай.

7.1. "**Орон байр**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолын 1.9-д зааснаар ойлгоно.

Энэ заалтын "**нэвтрэх**" гэж иргэний орон байранд зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар орохыг хэлнэ.

7.2. "**Дур мэдэн орж суух**" гэдэгт иргэний орон байранд зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар нэвтрэн орж, түр болон бүр мөсөн суусныг ойлгоно.

7.3. "**Орон байрнаас гаргах**" гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан хуулийн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр иргэнийг орон байрнаас нь хууль бусаар, түр болон бүр мөсөн гаргасныг хэлнэ.

7.4. "**Нэгжлэг хийх**" гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин нэгжлэгийг явуулж, орон байрны халдашгүй байдлыг зөрчсөнийг ойлгоно.

8. Хуулийн 138 дугаар зүйлийн 138.1-д заасан "**хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахиж хангуулах үүрэг бүхий этгээд**" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу энэ ажлыг шууд хариуцаж байгаа аливаа этгээд хамаарна.

Мөн зүйлийн 138.2-т заасан "**бусад хүнд хор уршиг**" гэдэгт тодорхой нутаг дэвсгэрт нийтээр өвчлөх, хордох, хүний бие махбодид хүнд гэмтэл эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учруулсан зэргийг ойлгоно.

9. Хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасан "**зохиогчийн эрх**" нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээдэд хамаарна.

Энэ зүйл, хэсэгт заасан "...**түүнд хамаарах бүтээл**"-д мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан бүтээлүүдийг хамааруулж үзнэ.

10. Хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1-д заасан "**шинэ бүтээл**", "**бүтээгдэхүүний загвар**", "**ашигтай загвар**" гэдгийг Патентийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т тус тус зааснаар ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "**ашиг олох зорилгоор**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1.2-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

11. Хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1-д заасан "**шашны харгис үзэл номлол**" гэдэгт шашнаар дамжуулан сурталчилж, тараасан үндэс угсаа, нийгмийн гарал, арьс өнгө, амьдралын хэв маяг, уламжлал, хэл соёл, өөр шашин шүтдэг эсхүл эс шүтдэгээр нь ялгаварлан гадуурхах, өөр хоорондоо нь дайсагналцуулах, аллага хядлага, амиа хорлох, цусан өшөө авах, хүний эрх, эрх чөлөөг хориглох, хязгаарлахад чиглэсэн аливаа үзлийг хамааруулна.

12. Хуулийн 130 дугаар зүйлийн 130.2, 137 дугаар зүйлийн 137.1, 142 дугаар зүйлийн 142.1, 143 дугаар зүйлийн 143.1-д тус тус заасан "**хүч хэрэглэж буюу хэрэглэхээр заналхийлэх**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т заасанаар ойлгоно.

13. Хуулийн 130 дугаар зүйлийн 130.2, 142 дугаар зүйлийн 142.1-д тус тус заасан "**эд мөнгөөр татах**" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 4-т заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**
**ШҮҮГЧ Ч.ГАНБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2009 оны 07 дугаар сарын 14-ний өдөр** — **Дугаар 27** — **Улаанбаатар хот**

### "ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ" ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

"Өршөөл үзүүлэх тухай" 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулийн зарим зүйл, хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. "Өршөөл үзүүлэх тухай" хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, хэсгийг дор дурдсанаар тайлбарласугай.

1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан "**гэмт хэрэг үйлдсэн этгээд**" гэдэгт 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн хүмүүс хамаарна.

1.2. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан "**гэмт хэрэг үйлдэж, анх удаа хорих ялаар шийтгүүлсэн**" гэдэгт урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүйгээс гадна хорихоос өөр төрлийн ял шийтгүүлж байсан, хорих ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасанаар ялгүйд тооцсон буюу ялгүй болсон, хорих ялыг нь тэнсэж, хянан харгалзсан болон мөн хуулийн 62, 63 дугаар зүйлд заасанаар шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдээгүй, уг хугацаа дуусcан, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн боловч нэг шийтгэх тогтоолоор анх удаа хорих ял шийтгүүлсэн болон шийтгүүлж байгаа этгээдийг тус тус хамааруулан үзнэ.

1.3. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "**арван найман насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэгт ял эдэлж байгаа**" гэдэгт гэмт хэрэг үйлдэхдээ насанд хүрээгүй байсан боловч уг хууль хүчин төгөлдөр болох үед 18 насанд хүрсэн этгээдийг ойлгоно.

1.4. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан "**арван найман насанд хүрээгүй хүүхэдтэй**" гэж нэг

буюу түүнээс дээш төрүүлсэн болон үрчилж авсан, түүнчлэн нэг өрхөд хамт амьдарч байгаа дагавар хүүхдийн аль нэг нь уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө 18 насанд хүрээгүй байхыг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан **"жирэмсэн..."** болох нь эмчийн магадлагаа, эсхүл эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон байвал зохино.

1.5. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан **"өөрийн шууд асрамжинд байгаа арван найм хүртэл насны хагас өнчин хүүхэдтэй"** гэж шууд асрамжинд нь байгаа төрсөн болон үрчилж авсан, дагавар хүүхдийн эх нь нас барсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон байхыг хэлнэ.

1.6. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д дурдсан өршөөлд хамааруулах үндэслэл нь 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө шүүхийн хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоол, шийдвэр, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх /паспорт/, түүнтэй адилтгах бусад баримт бичиг, Иргэний бүртгэлийн тухай хуульд заасан төрийн захиргааны эрх бүхий байгууллагын бүртгэл, тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын дүгнэлт зэргээр тогтоогдсон байвал зохино.

1.7. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан **"энэ хуулийн 4.1.5-д заасан этгээдэд энэ хуулийн 8.1.7 дахь заалт хамаарахгүй"** гэдгийг 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн, түүнчлэн ял эдэлж байгаа **"арван найман насанд хүрээгүй хүүхдэд"** уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт хаалт болохгүй гэж ойлгоно.

1.8. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан **"болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн ялтан"** гэдэгт хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэргийг анх удаа болгоомжгүй үйлдсэн болон ял шийтгүүлсэн этгээд хамаарна.

1.9. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан **"хорихоос өөр төрлийн хөнгөн ял"** гэдэгт Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах ялыг тус тус ойлгоно.

1.10. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан өршөөлд хамааруулах үндэслэлийг **хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын** хяналтын болон **шүүхийн** шатанд тус тус шалган тогтоосон байвал зохино.

1.11. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2-т заасан **"хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж"** гэдэгт уг гэмт хэргийг санаатай үйлдсэн байхыг ойлгоно.

1.12. Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж, нэг шийтгэх тогтоолоор ял шийтгүүлсэн ялтанд шүүх энэ хуульд заасан өршөөлийг үзүүлэхдээ зүйл, хэсэг тус бүрээр оногдуулсан ялд тохирох өршөөлийг үзүүлсний дараа үлдсэн ялын хөнгөнийг хүндэд нь багтаах, эсхүл бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэх зэргээр мөн хуулийн 57, 58 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

Харин ял эдэлж байгаа ялтанд өршөөл үзүүлэхдээ өршөөлд хамаарах зүйл, хэсэг бүрээр оногдуулсан ялд тохирох өршөөл үзүүлж, өршөөлд үл хамаарах ял буюу ялын үлдэх хэсгийг эдлүүлэхээр тогтооно.

1.13. Хуулийн 6 дугаар зүйлд заасан өршөөлийг үзүүлэхэд шүүхээс ямар нэг шийдвэр гаргах шаардлагагүй бөгөөд Цагдаагийн байгууллага уг хуулийн заалтыг баримтлан ялтны хувийн хэрэг, ял шийтгэлийн тухай тэмдэглэл /бүртгэл/-д өршөөл үзүүлсэн тухай зохих тэмдэглэгээг хийнэ.

1.14. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийн хувьд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шалгагдаж байгаа хэргийг **прокурор**, яллагдагчийг шүүхэд шилжүүлээгүй тохиолдолд **шүүгч** захирамж гаргаж, яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн тохиолдолд шат шатны **шүүх** хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Хэрэв сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугийн асуудлаар маргавал шүүх хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан ердийн журмаар хянан хэлэлцэж, гэм буруутай эсэхийг шийдвэрлэсний эцэст энэ хуулийг хэрэглэнэ.

1.15. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан **"гурав ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн"** гэдгийг 3 ба түүнээс дээш удаа шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгүүлсэн гэж ойлгоно.

Харин Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд зааснаар ялгүйд тооцогдсон буюу ялгүй болсон бол энэ ойлголтод хамааруулахгүй.

1.16. Хуулийн 8 дугаар зүйлд заасан өршөөлд хамааруулахгүй үндэслэлүүд нь 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө бий болсон байвал зохино.

1.17. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-ээс 8.1.7-д заасан этгээдэд уг хуульд заасан өршөөл үл хамаарна.

1.18. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг энэ хуульд заасан аль илүү ашигтай үндэслэлээр нэг удаа өршөөлд хамааруулна.

1.19. Ялтныг үндсэн болон нэмэгдэл ялаас энэ хуульд зааснаар өршөөн хэлтрүүлэх тухай асуудлыг Улсын Их хурлын 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 53 дугаар тогтоолоор байгуулагдсан комисс зохион байгуулна.

Өршөөл үзүүлэх тухай хуулийг шүүх буруу хэрэглэсэн тохиолдолд дээд шатны шүүх уг хэргийг давж заалдах буюу хяналтын журмаар хянан хэлэлцэхдээ алдаа, зөрчлийг залруулан зөвтгөж байвал зохино.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** **С.БАТДЭЛГЭР**
**ТАНХИМЫН ТЭРГҮҮН** **Д.БАТСАЙХАН**
**ШҮҮГЧ** **Б.ДОРЖГОТОВ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
**Хаяг:** <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 6